

**Нутгийн аялгуу – аман аялгуу – салбар аман аялгуу,
завсрын аман аялгуу хэмээх нэр томъёонуудыг тогтоох нь**

*Гэрэлт-Одын БАТЗАЯА**

*Монгол Улс, Улаанбаатар, Шинжлэх Ухааны Академийн
Хэл зохиолын хүрээлэнгийн Хэл шинжлэлийн салбар*

Received: May 15, 2025 | **Accepted:** September 29, 2025 | **Published:** October 15, 2025

Хураангуй: Монгол хэл шинжлэлд “Аялгуу судлал” хэмээх нэрээр гол төлөв нутгийн аялгууны судалгаа хөгжиж ирсэн билээ. Харин нийгмийн аялгуу судлал шинэ тутам хөгжиж байна. Нутгийн аялгуу судлал хэдийгээр олон арван жил хөгжсөн боловч, тухайн салбар ухааны үндсэн нэр томъёонуудыг хэл шинжлэлийн толь бичгүүдэд оновчгүй, дутуу дулим, хангалтгүй тайлбарлаж, орос болон англи хэлний ямар нэр томъёотой дүйх тухайд тодорхой ойлголтгүй байсаар өдий хүрчээ. Түүнчлэн олон монгол хэл аялгууны алиныг нь хэл, алиныг нь аялгуу гэж үзэх, аман аялгуу, салбар аман аялгуунуудыг ямар шалгуураар хэрхэн тогтоож ангилах талаар эрдэмтэн судлаачдын санал зөрүүтэй байсаар байна. Иймээс нутгийн аялгуу – аман аялгуу – салбар аман аялгуу ба завсрын аман аялгуу хэмээх нэр томъёонуудаар илэрхийлэх ойлголтуудыг судалгааны үндэстэй нэг мөр, бүрэн гүйцэд тодорхойлж тайлбарлах, оноох, жич орос, англи хэлний ямар нэр томъёотой дүйлгэх талаар тодруулах, гүйцээхийг эрмэлзэн тус өгүүллийг бичлээ.

Түлхүүр үгс: нутгийн аялгуу, аман аялгуу, салбар аман аялгуу, завсрын аман аялгуу

* ©Г.Батзаяа, 2025

Email: batzaya.g@mas.ac.mn



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license.

On the Terms Dialect - Subdialect - Branch of Subdialect, and Intercurrent Subdialect

BATZAYA Gerelt-Od

Department of Linguistics, Institute of Language and Literature,
Mongolian Academy of Sciences, Ulaanbaatar, Mongolia

Abstract: In Mongolian linguistics, the study of local dialects has historically developed under the umbrella of Dialectology. While sociolinguistics is a relatively new field, the long-standing tradition of dialect studies still faces significant terminological challenges. Terms such as Dialect, Local dialect, Subdialect, Branch of a subdialect, and Intercurrent dialect are often inadequately or imprecisely defined in linguistic dictionaries. Moreover, there is a lack of clarity regarding how these terms correspond to their Russian and English equivalents. Scholars also continue to disagree on what constitutes a “Language” versus a “Dialect,” as well as on how to establish and classify subdialects and their branches. This article aims to address these issues by providing a consistent, comprehensive, and research-based clarification of the aforementioned terms.

Key words: related language, dialect, subdialect, branch of subdialect, intercurrent subdialect

1. Удиртгал

Монгол хэлний нутгийн аялгуу судлалын үндсийг XIII зуунаас эхлэн авч үзэж болно¹. Харин XIX зуунаас хойш өнөөг хүртэл бие даасан салбар ухаан болон хөгжсөн юм. Ийнхүү хөгжих эхэн үед монгол хэл аялгуунуудыг хэрхэн ангилан хуваах тухайд харилцан адилгүй санал дэвшүүлж иржээ. Монгол хэлтэн хэмээх нэгэн нэрийн доор багтах олон нутгийн аялгуу байна гэх, тус тусдаа бие даасан хэд хэдэн монгол хэл байх бөгөөд тэдгээр нь дотроо олон, цөөн нутгийн аялгуутай хэмээх үндсэн хоёр санал олон жил үргэлжилжээ. А.Д.Руднев (1908), Г.И.Рамстедт (1908), Б.Я.Владимирцов (1929), Г.Гантогтох (2018) нарын эрдэмтэд² эхний саналыг баримталж байв. Харин Н.Н.Поппе

¹ XIII-XIV зууны Рашид-ад-дины “Судрын чуулган” нь ойрадын анхны сурвалж бичиг бөгөөд ойрад хүний хэл яриа бусад нутгийн хүнийхээс өвөрмөц ялгаатай болохыг тэмдэглэжээ. Мөн түүнчлэн, 1648 онд Ойрадын Зая бандида Намхайжамц тод үсгийг ойрад аялгууны онцлогт, 1686 онд Өндөр гэгээн Занабазар соёмбо үсгийг халх аялгуунд, 1905 онд Буриадын лам Агваан Доржиев вагиндра үсгийг буриад аялгуунд тус тус суурилан зохиосон, 1730 онд Ф.И.Страленберг “Халимаг-орос толь” бүтээсэн зэрэг нь монгол хэлний нутгийн аялгуу судлал хөгжихийн үндэс болсон юм.

² А.Д.Руднев. Опыт классификация монголов по наречьям. (“Сравнительная фонетика”. Москва, 1908. IV-V)

Г.И.Рамстедт. “Сравнительная фонетика монгольского письменного языка и халхаско-ургинского говора”. СанктПетербург. 1908. (Орчуулга, “Хэл зохиол”. УБ., 1967, 4. I-IV)

Б.Я.Владимирцов. “Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия”. Ленинград, 1929

(1936), Г.Д.Санжеев (1957), Чингэлтэй (1957), Г.Дөрфер (1964), Д.Төмөртоогоо (1992), Ю.Янхунен (2003), Ж.Цолоо ([2008] 2011) нарын эрдэмтэд³ хоёр дахь саналыг баримталж иржээ. Академич Ш.Лувсанвандан Улаанбаатар хотноо 1959 онд болсон олон улсын монгол хэл бичгийн эрдэмтний анхдугаар их хуралд хэлэлцүүлсэн илтгэлдээ дээрх эрдэмтдийн ангиллыг үнэлж дүгнээд, өөрийн шинэлэг саналыг дэвшүүлсэн байна. Тэр бээр “Монголын эзэнт гүрэн задарсны дараагаар Афганистаны моголууд, мөн Ганьсу мужийн монгорууд, төв монголчуудаасаа улс төр, соёл, эдийн засгийн талаар бүрмөсөн тасарсан боловч ар, өвөр монголчууд, мөн ойрад, буриад монголчууд бие биеэсээ ингэж бүх талаар тасарсангүй учраас тэдний хэл аялгуу ч мөн тус тусдаа биеэ даасан төрөл хэл болон хөгжсөнгүй, нэгэн монгол хэлний салбар аялгуу, аман аялгуу хэвээр үлджээ... Түүнчлэн Хөхнуур, Эзнээ гол, Алшаагийн монголчуудын үг хэл нь гарлаараа ойрад аялгуу боловч одоо төв аялгуу руу хэлбийж, завсрын аман аялгуу болжээ. Мөн барга буриад нь халх-буриадын завсрын аман аялгуу юм...” (Лувсанвандан, [1959] 2002: 38-45) хэмээн гол төлөв өөр хоорондоо хэрхэн харилцан нэвтрэлцэж байгаагаар нь баримжаа болгож, монгол угсаатны түүх нийгмийн хөгжилтэй холбон тайлбарлаж, хилийн чанадад орших ойрад, буриад, өвөр монголчуудын хэлэлцэх хэл аялгууг хамруулж монгол хэл: өрнөд аялгуу (Шинжааны ойрад, Ижил мөрний халимаг), умард аялгуу (Байгалын урд биеийн буриад, Байгалын хойд биеийн буриад), төв аялгуу (халх, цахар, ордос), дорнод аялгуу (хорчин, харчин), төв өрнөдийн завсрын аман аялгуу (Хөхнуур, Алшаа, Эзнээ гол, Ховдын ойрад), төв умардын завсрын аман аялгуу (сэлэнгэ, барга), төв дорнодын завсрын аман аялгуу (баарин, ар хорчин, найман, онниуд) гэж ангилсан байна. Ийнхүү ангилахдаа хилийн чанад дахь Халимаг Улс, Буриад Улс, түүнчлэн Өвөр Монголын Өөртөө Засах Орны хүн амын хэлэлцэх хэл яриаг монгол хэлний аялгуу гээд, өрнөд, умард, дорнод, төв аялгуунаас гадна завсрын аман аялгуу гэдэг нэр томъёог дэвшүүлжээ. Харин могол, монгор зэргийг оруулсангүй. Үүнээс хойш монгол хэлнүүд, аялгуунуудыг олон эрдэмтэн судлаач өөр өөрийн үзэл баримтлалаар ангилан хувааж ирсний дотор нутгийн аялгуу судлаач эрдэмтэн Ж.Санжаа нар 2005 онд “Монгол хэлний нутгийн аялгууны байршлын зураг” бүтээж, Монгол Улс дахь монгол хэлийг нутгийн аялгуу, аман аялгуу, салбар аман аялгуунуудад ангилан хувааж, хэлэлцэгч хүн амын байршлыг аймаг

Г.Гантогтох. Монгол хэл аялгуунуудын харьцуулал. (“Монгол хэл, аялгуу, үсэг бичгийн судлал” эрдэм шинжилгээний өгүүллийн чуулган. УБ., 2018. 129-131)

³ Н.Н. Поппе. “Строй халха-монгольского языка”. Ленинград. 1936

Г.Д.Санжеев. “Монгол хэл аялгууны учир”. (Орчуулсан Ш.Лувсанвандан). УБ., 1957

Čenggeltei, “Dumdadu ulus daki mongyol törül kele ba nutuy-un ayalyun-u yerühkei bayidal” [1976]. (“Čenggeltei-yin jokiyaal бүтүгел-үн тегүбүри”. Ulaanqada, 2010)

G.Doerfer. “Classification und Verbreitung der mongolischen Sprachen”. HdO 1964. 5:2

Д.Төмөртоогоо. “Монгол хэлний түүхэн хэлзүй”. УБ., 1992

J.Janhunen (ed.), The Mongolic Languages, Pouledge Language Family Series. London, New-York, 2003

Ж.Цолоо, БНМАУ-ийн нутгийн аялгуу (“Хэл зохиол судлал”, Боть XVIII. УБ., 1982). “Орчин цагийн монгол хэлний нутгийн аялгуу”. УБ., 2011

сумдаар нь ялган тэмдэглэсэн бөгөөд түүндээ завсрын аман аялгуу гэдэг нэр томъёог оруулаагүй байна. Монгол хэл, аялгуунуудын олон янзын ангилал нь хүн амын угсаа гарал, түүхэн замнал, нүүдэл суурьшил, нутгийн аялгууны хөгжил хувьсал, улс орны хил хязгаар, улс төрийн үзэл баримтлал, нутгийн аялгуу судлалын ухааны хөгжил гэх мэт хэлний ба хэлний бус олон хүчин зүйлтэй холбоотой юм. Түүнээс гадна аливаа хэл, ялангуяа амьд аман яриа тасралтгүй хувьсан хөгжиж байдаг учраас ойр зэргэлдээх бусад хэл, аялгууны нөлөө орох, ижилсэх, ялгарах, явцуурах, өргөжин хөгжих, хүн ам нь тухайн аялгуугаа хэрэглэхээ болих, мартах, сэргээх зэрэг хувиралт өөрчлөлт үргэлжилсээр байдаг. Иймээс хэл, аялгуу, түүний доторх аман болон салбар аман аялгууг ангилан хуваах явдал бол нэг удаа, нэг хүн хийгээд орхих ажил биш, тодорхой хугацааны давтамжтай, байнга хөгжүүлж, шинэчилж байх хэрэгтэй ажил юм.

2. Судалгааны арга зүй

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Хэл шинжлэлийн салбараас 2022-2024 онд хэрэгжүүлсэн “Монгол хэлний нутгийн аялгууны судалгаа” сэдэвт суурь судалгааны төслийн хамт олон монгол хэлний нутгийн аялгуутан, аман аялгуутан бүрийн, олонх салбар аман аялгуутны нутагт шинжилгээний ангиар явж, өнөөгийн байдлыг сурвалжлан судлав. Судалгааны явцад монгол хэлний нутгийн аялгууны хуваарилалтыг өнөөгийн байдлаар шинэчлэн тогтоох, ‘Монгол хэлний нутгийн аялгууны байршлын зураг’ шинээр хийх зайлшгүй шаардлагатай болох нь ажиглагдсан юм.

Харин нэр томъёоны хувьд өнөөг хүртэл үндсэндээ Ш.Лувсанванданы 1959 оны тайлбар, тодорхойлолтыг баримтлан, гол төлөв нутгийн аялгуу, аман аялгуу, салбар аман аялгуунуудыг ангилан, судалж иржээ. Түүнчлэн, зарим аялгуу завсрын шинжтэй болохыг дурдан тэмдэглэж байсныг эс тооцвол ‘завсрын аман аялгуу’ гэдэг нэр томъёог хэрэглэж, ангилалдаа оруулж судалсан хүн бараг байхгүй юм. Дээр тэмдэглэсэнчлэн нэгэнт бид монгол хэлний нутгийн аялгууны өнөөгийн байдлыг судлан, хуваарилалтыг шинэчлэн хийх хэрэгтэй болсон тул эдгээр нэр томъёоны тодорхойлолтыг эргэн харах, цэгцлэх, шинэчлэн найруулах зайлшгүй шаардлагатай гэж үзлээ. Үүний тулд бид монгол хэлний аялгуунуудын өнөөгийн байдлыг ажиглах, хэлний баримтуудыг галиглан бичиж авах, аудио, видео бичлэг хийж сан хөмрөг бүрдүүлэх, түүнийгээ задлан шинжлэх, аялгуу тус бүрийн өвөрмөц шинжийг нэгтгэн дүгнэх, өөр хооронд нь харьцуулалт хийж, хэлний ямар түвшинд хэрхэн ялгарах болон нэгдэх байдлыг тодорхойлох, улмаар хэлний тэрхүү онцлог шинж нь тухайн ард түмний угсаа гарваль, түүхэн замнал зэрэг бусад хүчин зүйлстэй хэрхэн холбогдож байгааг уялдуулан дүгнэлт гаргах зэрэг аргаар ажиллав.

Нутгийн аялгуу, аман аялгуу, салбар аман аялгуугаар хэлэлцэгчидтэй биечлэн уулзаж ярилцан, өдөр тутмын энгийн яриа, жич аман зохиол, уран зохиол зэргээс жишээ баримт цуглуулан, тухайн аялгууны дуудлагыг IPA (International Phonetic Alphabet) – олон улсын авианы галигаар тэмдэглэж, утгыг кирилл бичгийн зөв бичих дүрэмд захируулан бичив. Одоо хэл – аялгуу – нутгийн аялгуу – аман аялгуу – салбар аман аялгуу, завсрын аман аялгуу гэдэг нэр томъёонуудыг нэг нэгээр тайлбарлая.

3. Судалгааны хэсэг

3.1. Хэл (Язык - Language)

Ч.Зээнямбуу, М.Базаррагчаа нар “Хэл шинжлэлийн нэр томъёоны тайлбар толь”-доо: “Төрөл хэл (Cognate /related/ language) нь нэг үндсэн (өвөг) хэлнээс үүссэн хэл. Нэг үндсэн гаралтай боловч түүхэн элдэв үед салж тасран, тус тусдаа өөр өөрийн хөгжлөөр хөгжсөн хэлнүүд юм. Төрөл хэлийг дотор нь хол, ойрын төрөл хэл гэж ялгадаг. Жишээ нь: монгол хэл гэхэд (халх монгол, өвөр монгол), дагуур, буриад, ойрад-халимаг, монгор, могол, бао-ань дуншаан хэл нь ойрын төрөл хэлнүүд юм. Харин монгол, түрэг, манж, солонгос, япон хэл нь холын төрөл хэлнүүд болно” (Зээнямбуу нар, 348) гэж тайлбарлажээ.

Монгор, дагуур, дуншаан, бао-ань, зүүн ёгур, жич могол, канжя хэлнүүд төв монгол хэлнээсээ нэгэнт алслан холдож, өдгөө биеэ даасан хэл болон хөгжсөнийг эрдэмтэн судлаачид үндсэндээ хүлээн зөвшөөрч иржээ. Харин ойрад, буриад, мөн өвөр монголчуудын хэлэлцэж буй хэл яриа нь хэл үү, аялгуу юу гэдэг нь харилцан адилгүй саналын гол оногдохуун болоод байна.

Өнөөдрийг хүртэл Монгол Улсын монголчууд, Өвөр Монголын Өөртөө Засах Орны монголчуудын хэл яриаг нэгэн монгол хэл гэж үзсээр ирсэн эрдэмтэн судлаачид олон бий. Тухайлбал, 1996 онд Лондонд, 1998 онд Москвад хэвлэгдсэн “Атлас языков мира” (Дэлхийн хэлнүүдийн атлас)-д “Основным языком монгольской группы является язык на котором говорят в Монгольском народном республике и во Внутренней Монголии, автономном районе Китая.” / Үндсэн буюу төв монгол хэлээр Бүгд Найрамдах Монгол Улс, Өвөр Монголын монголчууд ба Хятад улсын доторх Монголын автономит мужийн монголчууд хэлэлцдэг/ (АЯМ., 1998: 47-48) хэмээсэн байдаг. Түүнчлэн 2004 онд Өвөр Монголын Улаанхад хотноо хэвлэгдсэн “Монгол судлалын нэвтэрхий толь (Үг хэл үсэг бичиг)”-ийн “Монгол хэл аялгууны тархацын байдал” зурагт ар, өвөр монголын хэлийг нэгэн өнгөөр, харин дагуур, дуншаан, могол, монгор, зүүн ёгур, бао-ань болоод халимаг, буриад хэлнүүдийг нэгэн ижил өнгөөр тэмдэглээд, монгол төрөл хэл (Mongolic languages) хэмээн нэрлэж, монгол хэлийг дотор нь өвөр (өвөр монгол) аялгуу, халх аялгуу, ойрад аялгуу, буриад аялгуу хэмээн дөрвөн том нутгийн аялгуунд хувааж үзсэн байна.

Гэхдээ сүүлийн үед ч энэ асуудал маргаантай хэвээр байгаагаас гадна хэл шинжлэлийн онол, зарчмын хувьд авч үзвэл эргэн харууштай асуудал хэвээр байсаар байна. Өвөр Монголын эрдэмтэн Сэцэнбаатар “Монгол хэлний нутгийн аялгууны шинжлэлийн удиртгал” хэмээх бүтээлийнхээ “Хэл хийгээд нутгийн аялгууны ялгаа” хэсэгт хэл үү, нутгийн аялгуу юу гэдгийг шийдэх тухай дараах хэд хэдэн үндэслэлийг тайлбарласан байна. Үүнд: Аливаа хэлний доторх нутгийн аялгуу бусад нутгийн аялгуутайгаа зэрэгцэн оршдог бөгөөд ганц нутгийн аялгуутай хэл гэж байдаггүй. Нэг хэлэн доторх нутгийн аялгуунуудын үгийн үндсэн сан хийгээд хэл зүйн зохион байгуулалт үндсэндээ адил байдаг. Гэхдээ дан ганц үгийн сан, хэл зүйн зөрөө их, багаар бас асуудлыг бүрэн тодорхойлж чадахгүй. Мөн хэл яриануудын хоорондох шилжилтийн чанартай зүйл байх эсэх, улс төрийн байгууламж харьяалал, бичиг

үсэг ба бичгийн хэл, нэг үндэстэн мөн эсэх нь асуудлыг шийдэх чухал хүчин зүйлс мөн боловч бас л бүрэн шийдвэрлэж дийлэхгүй. Тиймээс эдгээр нөхцөлийг дан дангаар нь бус нийтэд нь ерөнхийлөн харгалзсан суурин дээр, нэгд. хэл аялгууны тус биеийнх нь онцлогийг үндэслэж, хоёрт. тухайн хэл аялгуугаар яригчдын үзэл ухамсрыг үндэслэж байгаад хэл ба нутгийн аялгууны ялгааг тодорхойлж болох юм. Хэл аялгууны тус биеийнх нь онцлог гэдэгт: 1. Нэгдмэл нэг хэлний дотоод дахь хэл яриа болж байх, 2. Тогтсон нутаг дэвсгэрийн тархацтай, 3. Тухайн хэлнийхээ нийтлэг онцлогийг хадгалсан мөртөө зохих хэмжээний өвөрмөц онцлогтой, 4. Авиа зүй, хэл зүй, үгийн сан, утга зүйн системт чанартай хэмээх үндсэн онцлогуудыг үзэж, хамтын дотоод хөгжлийн жам хуульд захирагдах эсэхийг нь чухалчилна. Адил бус орон нутгийн хүмүүс өөрсдөө чухам юу гэж үзэх ухамсар нь хэл ба нутгийн аялгууны ялгааг тодлоход чухал үйлдэл үзүүлнэ (Сэцэнбаатар, 2005: 5-10). Академич Д. Төмөртоогоо “Өөр өөр улсад оршин сууж байгаа нэг хэлний салбар аялгуутанууд тус тусдаа бичигийн хэлтэй байвал тэдгээрийг биеэ даасан хэл гэж үзнэ гэсэн зарчим олон улсын хэмжээнд үйлчилсээр байна. Тэрхүү зарчмыг баримталвал дээрхи гурван улсад харьяалагдаж байгаа ойрад, буриадууд өөр өөр бичигийн хэлтэй байгаа учир тус тусдаа биеэ даасан хэл болж таарна” (Төмөртоогоо, 2017: 48) гэсэн зарчмыг дэвшүүлсэн байна. Үнэндээ өвөр монгол, буриад монгол, халимаг монголчуудын хэлэлцдэг хэл яриаг уг гарваль, түүхэн замнал зэрэг талаас нь харвал монгол хэлний нутгийн аялгуу; өнөөдөр хилийн чанадад өөр улс оронд амьдарч буй байдал, өөрийн гэсэн утга зохиолын суурь болон баримжаа аялгуутай, түүнийхээ зөв бичих, дуудах, найруулах хэм хэмжээтэй, өөрийн гэсэн хэвлэл мэдээллийн сүлжээтэй зэрэг байдлыг харвал бие даасан хэл – ийм хоёрдмол чанартай болсон байна. Тиймээс хэл-аялгуу гэсэн нэр томъёо дэвшүүлж байсан эрдэмтэд ч бий (Батзаяа, 2008). Гэвч цаашид монгол хэлний өргөн хүрээнд бүрэн цогц судалгаа хийхийн тулд монгол хэлний өнөөгийн байдал, хөгжлийн чиг хандлага, нутаг нутгийн монголчуудын аман ярианы бодит ялгааг харьцуулан судлахын учир эрхбиш ямар нэг ангилалд тулгуурлах зүй ёсны шаардлага бидэнд тулгарч байна.

ОХУ дахь Буриад Улс, Халимаг Улс болон бусад мужид тархан суурьшсан хүн амын хэлэлцдэг хэл яриа нь орос хэлний нөлөөнд ихээхэн автаж, холимог хэлний шинжтэй бие даасан буриад болон халимаг хэл болжээ. Харин Монгол Улсын баруун аймгуудаар нутагладаг ойрадууд болон зүүн хойд аймгуудаар нутагладаг буриадуудын тухайн аймаг, сумандаа ярилцдаг аман яриа нь ойрад болон буриадаараа байж, өөр өөрийн онцлогоо хадгалж байвч халх аялгуунд суурилсан монгол утга зохиолын хэлний зөв бичих, найруулах хэм хэмжээ бүхий бичгийн хэлэнд захирагдаж, аман хэл нь ч тодорхой хэмжээгээр уусан жигдэрч байгаа тул монгол хэлний аялгуунууд юм.

Өвөр Монголын Өөртөө засах Орон болон Шинжаан-Уйгурын Өөртөө Засах Орны хүн ам нь өөрсдөө монгол хэлтэн гэсэн үзэл бодолтой, баримжаа авиа – цахар аман аялгуу нь халх аялгуутай харьцангуй ойр дөт байдаг. Гэвч тэд Буриад Улс, Халимаг Улсын нэгэн адил өөрийн орны хил хязгаартай, худам монгол үсэгт суурилсан бичгийн хэлтэй, тэр нь өөрийн гэсэн зөв бичих, дуудах, найруулах хэм хэмжээтэй, суурь аялгуутай, дотроо бас нутгийн аялгуунууд, түүн дотроо аман ба

салбар аман аялгуунуудтай юм. Хэлэлцэгч хүн амын тоог авч үзвэл сахар аман аялгуутан эдүгээ 460000 орчим бөгөөд энэ нь өвөр монголчуудын 10,78% бол хорчин аман аялгуутан 2080000 орчим бөгөөд дангаараа 48,77%-ийг эзэлж байна (Үлдсэн 40,45% нь ордос, алшаа, баарин, харчин аман аялгуутнууд)⁴. Хорчин аман аялгуу нь үгийн сангаас гадна хэл зүй, авиа зүйн түвшинд хятад хэлний нөлөөг үлэмж хэмжээгээр хүртэж, өдөр тутмын аман яриаг нь Монгол Улсын хүн ойлгоход улам бүр төвөгтэй болж байна. Ийнхүү тэд хоёр хэлтнээс холимог хэлтний шинж рүү аажмаар шилжиж, буриад хэл, халимаг хэлний нэгэн адил бие даасан хэл болон хөгжиж байгааг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүйд хүрч байгаа юм. Харин нэр томьёоны хувьд академич Д.Төмөртоогоо Монгол Улсаас өмнөд зүгт байрлах газар нутгийн байршлаар нь “өмнөд монгол хэл” гэж нэрлэсэнтэй бид санал нэг байна. Тэрээр бас Шинжаан-Уйгурын Өөртөө Засах Орны монголчуудын ярьдаг монгол хэлийг “ойрад хэл” хэмээн нэрлээд, нийт 11 монгол хэл бий (Төмөртоогоо, 1992: II) гэсэн байна. Гэвч өвөр монгол эрдэмтэн судлаачид ӨМӨЗО, ШУӨЗО-ы монголчуудын хэлийг хараахан хоёр тусдаа хэл гэж үзэхгүй байгаа юм. ШУӨЗО-ы болон Хөхнуур, Ганьсу муж зэрэг газар тархан суурьшсан ойрад монголчуудын дотор угсаатны ухамсрын үүднээс тод үсгээ мэддэг, хэрэглэдэг хүмүүс цөөнгүй байдаг боловч албан ёсоор уйгуржин буюу босоо монгол бичиг үсгээ хэрэглэдэг. Харин “Хөхнуур мужийн Хуаннаны төвөд үндэстний өөртөө засах жеү Жяньжа шяны Кан-ян балгасанд нутгийн хэлээр ярилцдаг нэг бүлэг хотончууд байдаг. Тэдний хэл яриаг өнгөрсөнд бао-ань хэлний нэг нутгийн аялгуу гэж үзэцгээдэг байсан. Сүүлийн жилүүдэд эдгээр хотончуудын хэл яриаг монгол төрлийн бие даасан бас нэг хэл – канжя хэл гэж үзэх болж байна.

Ийнхүү, өнөөдөр МОНГОЛ ХЭЛ хэмээх ойлголтод монгол, өмнөд монгол, буриад, халимаг, дагуур, дуншаан, бао-ань, монгол, зүүн ёгур, канжя⁵, могол⁶ гэсэн 11 төрөл хэл багтаж байна. Гэхдээ өдгөө амьд хэрэглэгдэж буй нь 9 байна. Эдгээр нь тус бүр дотроо нутгийн болон аман аялгуунуудтай, тэдгээрийн дотор салбар аман аялгуунуудтай [Нутгийн аялгуу, аман аялгуу, салбар аман аялгуунуудын хуваарилалтыг: монгол хэл - Г.Батзаяа (2025), өмнөд монгол хэл - Сэцэнбаатар (2005), буриад хэл - Э.Раднаев (1991), халимаг хэл - Н.Н.Убушаев (2006), дагуур хэл - Хас-Эрдэнэ (2014), монгол, дуншаан, бао-ань, зүүн ёгур хэл - Сэцэнбаатар (2005) нарын бүтээлээс авав].

⁴ https://mn.wikipedia.org/wiki/Өвөр_Монголын_Өөртөө_Засах_Орон

⁵ Дээр зууны ерээд онд хийсэн байцаалтаар канжягийн хотончууд нийт 2000 гаруй хүн байх бөгөөд 480 гаруй нь канжя хэлээ мэддэг байсан гэнэ. Гэтэл Тайваний эрдэмтэн Сяо Сү Ин-ий сүүлийн үед хийсэн байцаалтаар одоо канжя хэлээр ярилцдаг хүн 180 орчимхон үлдээд буй. (Сэцэнбаатар, 2005: 91-92).

⁶ Германы эрдэмтэн М. Weiers-ийн мэдээлснээр Афганистан дахь моголчууд 3000 орчим буй. Тэд бүгд исламын шашин шүтдэг бөгөөд орчин үе болтол малжих амьдралын зан дадгалаа хадгалсаар байв. Тэд өөрсдийгөө “могол” гэдэг нь араб, перс хэлэнд “монгол”-ыг moghol гэдгээс болсон юм. 1970 онд Монгол улсад болсон олон улсын монголч эрдэмтдийн хоёрдугаар их хурал дээр S.Nomam гэгч могол хүн “Афганистаны могол хүн” гэдэг сэдвээр илтгэл тавьсан бөгөөд Херат муж дахь моголчуудын төвлөрөн суудаг Күнтүр, До рүди зэрэг хэдэн тосгоны настайчуул могол хэлээрээ харилцдаг гэж мэдээлсэн билээ. Холбогдол бүхий мэдээ сэлтээс үзэхэд моголчуудын дотор могол хэлээ мэддэг хүн одоо бараг байхгүй болсон төлөвтэй бөгөөд тэдний зарим нь перс хэлтэн, зарим нь пуштү хэлтэн ба тажик хэлтэн болсон байна. Могол хэл нь хэдийгээр мөхөх шатандаа орсон (буюу мөхсөн) боловч тухайн орны зарим хэл, аялгуунд түүний дэвсгэр давхарга (substratum) бас үлдэгдлийн шинжтэй оршиж байна гэж зарим судлагчид мэдээлсэн билээ” (Сэцэнбаатар, 2005: 96–97).

МОНГОЛ ХЭЛНҮҮД	ХЭЛ	НУТГИЙН АЯЛГУУ	АМАН АЯЛГУУ	САЛБАР АМАН АЯЛГУУ
МОНГОЛЬС- КИЕ ЯЗЫКИ	ЯЗЫК	ДИАЛЕКТ	ГОВОР	ПОДГОВОР
MONGOLIC LANGUAGES	LANGUAGE	DIALECT	SUBDIALECT	BRANCH OF SUBDIALECT
МОНГОЛ ХЭЛНҮҮД MONGOLIC LANGUAGES	1. МОНГОЛ ХЭЛ mongolian language (Халх аялгуунд суурилсан, кирилл бичигт тулгуурласан бичгийн хэлтэй.)	халх	Улаанбаатарын аман аялгуу	
			төв халх	төв халх
				говийн халх
				өвөрхангайн халх
				өрнөд халх
			баруун халх	элжигин халх
				сартуул
			зүүн халх	дорнод халх
				дарьганга
				халхажсан өвөр монгол
		халх-буриадын завсрын	цонгоол	
			монголжсон хамниган	
		ойрад	умард ойрад	дөрвөд
				баяд
			өмнөд ойрад	урианхай
				өөлд
				торгууд, хошууд
				захчин
			ойрад-халхын завсрын	мянгад
				хотгойд
			ойрад-халх-буриадын завсрын дархад	
			монголжсон	монголжсон мончоог, соёд-цаатан, тува
		монголжсон хасаг		
буриад	хори-агын буриад	хори буриад		
		ага буриад		
	буриадажсан хонгоодор			
буриад-халхын завсрын барга				
		цахар	цахар	
			авга сөнид	
			үзэмчин	

2. ӨМНӨД МОНГОЛ ХЭЛ South Mongolian language (Цахар аялгуунд суурилсан, худам монгол бичигт тулгуурласан бичгийн хэлтэй.)	өвөр монгол	өвөр монгол		хишигтэн
				урад
			ордос	өмнөд ордос
				хойд ордос
			алшаа эзнээ	алшаа
				эзнээ
			баарин	баарин
				онниуд
				найман
				ар хорчин
			хорчин	жалайд
				дөрвөд
	горлос			
	харчин			
	хүрээ			
	монголжин			
буриад	буриад			
	барга	хуучин барга		
		шинэ барга		
ойрад		дөрвөд		
		торгууд		

3. буриад хэл Buryat language (Хори аялгуунд суурилсан, кирилл бичигт тулгуурласан бичгийн хэлтэй.)	хори	хори	хори	
			ага	
			мухаршибир	
			эхирид	
			качуг	
			баргажин	
			байгал-хүдэр	
			ивалга	
			хонгоодор	алайр-унгин
				түнхэн-аха-захаамин
			цонгоол-сартуул	цонгоол
				сартуул
булагд	боохон			
	доод үд			

4. халимаг хэл Kalmyk language (Дөрвөд аялгуунд суурилсан,			бузав	
			дөрвөд	их дөрвөд
				бага дөрвөд
			торгууд	хошууд
			цаатан	

	кирилл бичигт тулгуурласан бичгийн хэлтэй.)		оренбург	
			урал	
		каракол халимаг		
5. дагуур хэл Dagur language	бүтхэ чичихаар шинжаан			
6. монгол хэл Mongour language	хүзү минхэ			
7. дуншаан хэл Dungsiyan language		сувенанба ванжиажи шежиажи		
8. бао-ань хэл Bonan language	жишишан түнрва			
9. зүүн ёгур хэл East yugur language		чинлүн кэнле		
10. могол хэл Mogul language	мөхсөн хэл			
11. канжя хэл Kanjia language	?			

Бүдүүвч 1. Монгол хэл, аялгуунуудын тогтолцоо

1.2. Аялгуу (Диалект - Dialect)

Мэргэжлийн бус хүмүүсийн дунд аялгуу, аялга⁷ гэдэг хоёр үгийг ялгаж ойлгодоггүй, хутгаж ярьдаг, адилхан ойлгодог тал бий. Тиймээс, аялгууны тухай ойлголтыг юуны өмнө аялгаас ялгаж салгаж ойлгох хэрэгтэй.

“Аялгуу” (перс. dialektos ‘яриа, аялгуу’) гэдгийг Ч.Зээнямбуу, М.Базаррагчаа нар “Газар нутаг, нийгэм, эрхэлж буй ажил мэргэжлийн чанараараа хүмүүсийн ижил төстэй нэгдмэл харилцааны нийтлэг хэрэглүүр болсон тухайн хэлний тодорхой төрөл зүйлийг аялгуу гэнэ. Аялгуу нь бусад аялгуу болон нийтийн хэлний төрлүүдтэй хэлний нийтлэг шинж чанараараа нэгдэхийн хамт мөн өөрийн өвөрмөц онцлогоороо ялгарах хандлагатай байдаг. Аялгууг нутгийн аялгуу, нийгмийн аялгуу гэж ангилдаг...” (Зээнямбуу нар, 2014: 29) хэмээн тодорхойлсон бол Ж.Бат-Ирээдүй нар “Монгол хэл шинжлэлийн тайлбар толь бичиг”-тээ “Газар нутаг, нийгмийн болон мэргэжлийн талаар нягт холбоо бүхий хэсэг

⁷ “Аялга гэдэг нь яриаг дагалдаж, түүнийг чимж байдаг дууны хүч, өөрчлөлт, хөдөлгөөн юм. Аялга нь өгүүлбэрийн утга болон сэтгэлийн хөдөлгөөний өнгө аясыг илэрхийлэх хэрэглүүр бөгөөд өөртөө олон зүйлийг агуулсан маш нарийн үзэгдэл. Аялгын бүрэлдэхүүнд ярианы явцад гарч буй хийн хүчнээс шалтгаалан дууг чангаруулж, сулруулах, ярианы удаан түргэн, ярианы өнгө, өргөлт, зогсосхийлт гэх мэт зүйл багтана” (Санжаа нар, [1993], [2008] 2018: 301).

бүлэг хүний харилцдаг тухайн хэлний (үндэстний хэлний) салбарыг аялгуу гэнэ. Аялгуу нь бусад аялгуу болон нийтийн хэлний төрлүүдтэй хэлний нийтлэг шинж чанараараа нэгдэхийн хамт өөр өөрийн онцлогоороо ялгарч байдаг... Аялгууг нутгийн аялгуу, нийгмийн аялгуу гэж ангилна” (Ж.Бат-Ирээдүй нар, 2014: 23) гэж тодорхойлжээ. Англи хэлээр нийгмийн аялгууг Social Dialect, нутгийн аялгууг Local Dialect гэж үгчлэн орчуулах боловч нэр томъёоны хувьд нийгмийн аялгууг Socialect, нутгийн аялгууг Dialect гэж хэвшжээ.

“Нийгмийн аялгуу гэдэг нь тодорхой нийгмийн бүлэг, ангийн ярьдаг хэрэглэдэг үг хэллэг, өгүүлбэр, эх, хэлний хэрэглээний нэгэн хэв шинж юм. Нийгмийн аялгуунд нийгэм, улс төр, эдийн засгийн байдал, боловсрол, ажил мэргэжил, түүнчлэн шашин шүтлэг, нас, хүйс, үндэс угсаа гэх мэт нийгмийн олон янзын хүчин зүйлс нөлөөлдөг. Идиолект (хувь хүний яриа), эколокт (гэр бүлийн яриа) ч нийгмийн хэлний хүчин зүйлийг бүрдүүлж, үгийн сонголт, хэл зүйн шинж чанар, утга найруулга, түүнчлэн тухайн хүн, гэр бүлд байх өвөрмөц үг хэллэг, хэлц үг, дуудлагаараа ялгарах шинжтэй... XX зууны 20, 30-аад оны үед үүсэж, нийгмийн шинжлэх ухааны салбар болох хэл судлалын чиглэлд ‘нийгмийн аялгуу’(социолект, соцдиалект) гэсэн нэр томъёогоор анх гарч иржээ. Гарлын хувьд латин хэлний *societas* (нийгэм) ба грек хэлний ‘*dialectos*’ (яриа, аялгуу) гэсэн үгээс үүдэлтэй бөгөөд Т.И.Ерофеева ‘социолект’ гэсэн нэр томъёог анх оноож хэвшүүлсэн байна” (Шинэбаяр, 2024: 11-12).

Аялгуунуудын ялгаа зааг буюу ялгарах өвөрмөц онцлог шинжийг аялгууны зааг гэдэг. Монгол хэлэнд халх, ойрад, буриад зэрэг нутгийн аялгуу байхын сацуу аль ч хэлний адил хотынхны, хөдөөгийнхний, залуусын, хөгшчүүлийн, хүүхдийн, өсвөр насныхны, улс төрийнхний, оюутнуудын, гэмт хэрэгтнүүдийн гэх мэт нийгмийн аялгуу байна.

1.3. Нутгийн аялгуу (Диалект - Dialect)

Нутгийн аялгууг орос хэлээр “диалект”, англи хэлээр мөн “*dialect*” гэдэг. Академич Ш.Лувсанвандан 1959 онд монголч эрдэмтний анхдугаар их хуралд хэлэлцүүлсэн “Монгол хэл аялгууны учир” хэмээх илтгэлдээ “Хэлнийхээ шинжээр ноцтой ялгавар байхгүй, харилцан өчүүхэн ч саадгүй нэвтрэлцэх бүлэг хүмүүсийн үг хэлийг аялгуу гэж нэрлэв. Нэг нутгийн аялгуу нөгөө нутгийн аялгуунаасаа хэлнийхээ шинжээр мэдэгдэхүйц ялгарна” (Лувсанвандан, [1959] 2002: 36-55) гэж тодорхойлжээ. Харин Ч.Зээнямбуу, М.Базаррагчаа нар “Нутгийн аялгууны үг нь тухайн үндэстний бичиг зохиолын хэлэнд байдаггүй буюу байгаа үг нь өөр хэлбэр дуудлагатай байдаг байна. Тухайн хэлний нэг нутгийн аялгуу нөгөөгөөсөө авиа, хэл зүй, үг бүтэх ёс, үгсийн сангийн хувьд ялгамжтай байдаг. Энэ ялгаа нь тухайн хэлтэн хүмүүс ойлгохооргүй их, харьцангуй бага ойлголцох зэрэг янз бүр байна...” (Зээнямбуу нар, 2014: 29) гэсэн бол Ж.Бат-Ирээдүй нар “Улс орны тодорхой нэгэн хэсэгт оршин суугаа, өвөрмөц ёс заншил, түүх, соёлын нэгдэл бүхий хүмүүсийн хэлийг нутгийн аялгуу гэнэ” (Ж.Бат-Ирээдүй нар, 2014:

103) гэж тодорхойлсон байна.

Эдгээр ойлголт, тайлбарыг нэгтгэн дүгнэж, монгол хэлний аялгуунуудын өнөөгийн байдлыг нягталж үзээд, бид дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд: Улс орны тодорхой нэгэн нутагт оршин суугаа, угсаа гарал, түүхэн замнал, ёс заншил, ахуй соёл зэргээрээ нэгдмэл бүлэг хүмүүсийн ярилцдаг, тухайн хэлний салбарыг нутгийн аялгуу гэнэ. Нутгийн аялгуунууд өөр хоорондоо аман хэлний хүрээнд авиа зүй, хэл зүй, үгийн сангийн түвшинд нэлээд ялгаатай боловч тухайн хэлнийхээ нийтлэг шинжийг хадгалж, бичгийн хэлэнд захирагдана. Орчин цагийн монгол хэл нь:

I. Халх

II. Ойрад

III. Буриад гурван нутгийн аялгуутай.

Халх аялгуу нь бусад аялгууны дундын шинжтэй, эгшгийн балархайшилт, үгийн урт дундаж хэмжээтэй, хувьсал хөгжлийн хувьд түүчээлэх чанартай, орчин цагийн монгол хэлний кирилл бичгийн хэлтэй харьцангуй ойрхон бөгөөд бичгийн хэлний суурь аялгууг багтаадаг. “Халх аялгуу нь нийгэм соёлын түүхэн онцлог болон туулж өнгөрүүлсэн хэлний хөгжлийн замналаараа бусад аялгуунаас нэлээд ахиж, үлгэр жишээ болохуйц аялгуу болж чадсан. Халх аялгуу нэгдмэл шинжтэй бөгөөд монгол хэлний олон нутгийн аялгуунд зууч болж, аялгуунуудын өөр хоорондоо ойлголцох хэрэглүүр болон үйлчилсээр иржээ” (Санжаа нар, [1993], [2008] 2018: 25-26). Өдгөө халхчууд Монгол улсын нийслэл болон 21 аймагт тархан суудаг бөгөөд 2020 оны хүн амын дэлгэрэнгүй тооллогоор халх аялгуутан 2659985 байсан нь улсын нийт хүн амын 83,8%-ийг эзэлж байна. Дарьганга, үзэмчин, харчин, сартуул, элжигин болон завсрын, халхажсан аялгуут нэгтгэвэл 2705793 хүн (85,25%) байна⁸.

Ойрад аялгуунд бусад аялгуунаас ялгарах онцлог шинж цөөнгүй бий. Авиа зүйн хувьд: халх, буриад аялгууны [ө], [у] эгшгийг [ш], [y] гэж илүү урдуур хэлдэг, [ж] эгшиг нь харьцангуй агуу бөгөөд урдуур байранд бүтдэг өвөрмөц эгшиг юм. Эгшгийн балархайшлын хувьд монгол хэлний аялгуунуудаас хамгийн их атлаа үгийн тэргүүн бус үед (ö), (y) эгшгийг тодорхой хэлдэг онцлог бий. [œ:], [y:] эгшиг нь гол төлөв [ш:], [y:] эгшигт шилжсэн ([tʰʃ:ɣy:] – *тойруу*, [y:tʰən] – *уйтан* гэх мэт). Зарим үгийн тэргүүн үеийн [i] эгшиг ухран ижилсээгүй ([miχn] – *мах*, [ʃiɣvæt] – *жаргал* гэх мэт), [n], [ŋ] гийгүүлэгчүүд бие биеийнхээ байранд харилцан тохиолддог. ([χarsən] – *харсан*, [jəwsn] – *явсан*; [ertən] – *эрдэнэ*, [ertənpatʰ~ertəmpatʰ] – *Эрдэнэбат* гэх мэт). [x] гийгүүлэгчийг [kʰ] гэж хэлдэг ([kʰetən] – *хэдэн*, [kʰiɣu:] – *хяруу*, [tʰakʰa:] – *тахиа* гэх мэт). Эгшиг зохицох ёс халх, буриад аялгуунуудаас өөр: [ɔta:] – *одоо*, [pəɫär] – *балор*, [zəkʰa:χ] – *зохиох*, [tʰemʃ:n] – *тэмээ*, [kʰʃtʃ:] – *хөдөө* гэх мэтээр тэргүүн үедээ ямар ч эгшигтэй үгийн тэргүүн бус үед [ä], [a:], [ж], [ж:] эгшгүүд ордог. Хэл зүйн хувьд, олон тооны [-mo:t/-my:t], [-nərmə:t/-nərmɣ:t], [-so:t/-sy:t] гэх мэт өвөрмөц нийлмэл

⁸ hun_am_toollogo.pdf&ln (Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын нэгдсэн дүн)

дагавруудтай, харьяалахын тийн ялгал нь [-a:ŋ/-ж:ŋ], [-a:/-ж:], [-i:ŋ/-г:ŋ], чиглэх тийн ялгал нь [-o:r/-y:r] нөхцөлтэй, холбох [-la:/-лж:], хэмжих [-ts^ha:/-ts^hж:] тийн ялгалтай. Бие заах нөхцөлтэй. ([pi awnəw] – *би авна*, [pit awnəft^h] – *бид авна*, [awno:ŋ^h] – *авах уу чи*, [awno:t^h~awənt^h] – *авах уу та*). Үйл үгийн [-tək] нөхцөл нь хураагдаж ганц [-t] гийгүүлэгч болдог бөгөөд аль ч цагийг заадаг өргөн хэрэглээтэй. Жишээ нь: [pi xət^h ɔrtāk] – *Би хот ордог /орно/* (ирээдүй цаг). [nat ɛrt^hy:r k^hɛlty:ŋ] – *Над эртээр хэлдэгүүш /хэлсэн шүү дээ/*. [ɬn ɬy:n pɔsa:t t^hy:t^hж: jɜrtək] – *Өнөө өглөө босоод түүнтэй ярьдаг* (өнгөрсөн цаг). [t^hɛr tsamta:n jɔwtpɔlɣ] – *Тэр замдаан явдаг болох /яваа байх/* (одоо цаг). [t^hɛr mɬɪ irti:m] – *Тэр мөн л /дандаа/ ирдэг юм* (байнга цаг).

Үйл үг хоёрдугаар биед хүндэтгэх [-t^hən], [-t^ho:/-t^hy:] зэрэг өвөрмөц нөхцөлтэй. Үгийн сангийн хувьд бас халх, буриадаас ялгаатай өвөрмөц үг олонтой. Тухайлбал, Ж.Цолоо 1988 онд хэвлүүлсэн “БНМАУ дахь монгол хэлний нутгийн аялгууны толь бичиг (II. Ойрад аялгуу)”-тээ халх аялгуунаас авианы ихээхэн ялгаатай, хэл зүйн бүтэц өөр, эсвэл өөр язгуур үндэстэй ойрад аялгууны 4000 гаруй толгой үгийг салбар аман аялгуу бүрээр тайлбарлан оруулсан байдаг. Газар нутгийн хувьд өдгөө Монгол Улсын Увс, Ховд, Баян-Өлгий аймагт төвлөрөн, Хөвсгөл аймгийн зарим сум, Сэлэнгэ, Завхан, Архангай аймгийн цөөн суманд тархан суурьшиж байна. 2020 оны Монгол Улсын хүн амын дэлгэрэнгүй тооллогоор: дөрвөд 83719, баяд 63775, урианхай 29021, өөлд 14666, торгууд 15596, мянгад 8125, хошууд 382, захчин 37407, дархад 24549, хотгойд 8583, цаатан 208, хотон 12057, тува 2354 хүн тоологдсон⁹ бөгөөд нийтдээ 333574 (МУ-ын нийт хүн амын 10.5%) ойрад аялгуутан байна.

Буриад аялгуунд бас бусад аялгуунаас ялгарах онцлог шинж цөөнгүй бий. Авиа зүйн хувьд: богино [ə] эгшиг нь халх аялгууны [e]-ээс хойгуур, эр чанга [ɪ], [ɪ:] эгшигтэй, богино [ə] эгшгийн байранд [u] хэлдэг, хамжин шүргэх [ts], [ts^h], [tʃ], [tʃ^h] гийгүүлэгчийн байранд сул шүргэх ба шүргэх [z], [s], [ʒ], [ʃ] хэлдэг, [s] гийгүүлэгчийн байранд [h] хэлдэг, сул дуугүй [q], [k], [t], [p], [t^h]-ийн байранд сул дуутай [ɕ], [g], [d], [b], [l] хэлдэг, монгол хэл, аялгуунуудын дотроос эгшгийн балархайшилт хамгийн бага. Хэл зүйн хувьд: заахын тийн ялгал (-i:je/-i:je/-je), гарахын тийн ялгал (ha:/-he:/-hɔ:/-hɔ:)-ын нөхцөлүүд нь онцлог, бие заах нөхцөлтэй (bi jaβxəβ – *би явна*, bide jaβxəβdi – *бид явна*, ʃi jaβɪ:ʃ – *чи яваач*, t^ha jaβɪ:t^h – *та явна уу*) гэх мэт онцлог байна. Мөн цөөнгүй өвөрмөц үгийн сантай. Г.Гантогтохын “Буриад аялгууны толь” (2010/2011)-д 7000-аад толгой үг оруулсан нь халх аялгуунаас өөр язгууртай, өөр бүтэцтэй, эсвэл авианы нэлээд хувьсалтай үгс байна. Газар нутгийн хувьд хори буриадууд Хэнтий, агын буриадууд Дорнод аймгийн нутагт төвлөрч, хонгоодор буриадууд Хөвсгөл, Булган аймгийн цөөвтөр суманд, баргачууд Дорнод, Төв аймгийн цөөн суманд тус тус төвлөрч, өөр хоорондоо болон халх, бусад угсаатантай холилдон, айлсан аж төрж байна. 2020 оны хүн амын дэлгэрэнгүй тооллогоор: нийт 46877 хүн тоологдсон⁷ бол судлаач М.Дөш иргэний бүртгэлээс ургийн овгоор нь хөөж судлаад 101980 буриад иргэн байгааг тогтоож, “Ургийн овог нь буриадын аль нэг

овог хэрнээ ‘халх’ гэсэн үндэс угсаагаар бүртгэгдсэн нь маш олон байна” (Дөш, 2025: 107-108) гэжээ. Энэ нь Монгол Улсын хүн амын 3,21% болно.

1.4. Аман аялгуу (Говор - Subdialect)

Аман аялгууг орос хэлээр “говор”, англи хэлээр “subdialect” гэдэг. Академич Ш.Лувсанвандан “Хэлнийхээ шинжээр ерийн хэлэлцэхэд ялгавар байхгүй, нэг нутгийн бүлэг хүмүүсийн үг хэлийг аман аялгуу гэж нэрлэв. Нэг аман аялгуу нь нөгөөгөөсөө нарийвчлан ажиглавал хааяа авиан зүй, үгсийнхээ сангийн талаар өчүүхэн ялгарна” (Лувсанвандан, [1959] 2002: 36-55) хэмээн тодорхойлжээ.

“Монгол хэл шинжлэлийн тайлбар толь бичигт “Ард нийтийн хэлний нэгэн салбар буюу тухайлбал Монголын баяд, буриад, дөрвөд, захчин, халх гэх мэт үндэстний доторх аль нэг аймаг угсаатны хэлэлцдэг хэл яриаг аман аялгуу гэнэ. Янз бүрийн түвшинд хэлний бүтцийн нэлээд онцлог шинжтэй. Аман аялгуу бүхэн авиа дуудлага, хэл зүй, үг бүтэх ёс, үгийн сангийн хувьд өөрийн гэх онцлог ялгаатай байдаг. Тэр нь хоорондоо харилцахад нөлөөлдөггүй” (Бат-Ирээдүй нар, 2014: 13) гэжээ.

Эдгээр тайлбарыг нэгтгэн дүгнэж, монгол хэлний аялгуунуудын өнөөгийн байдлыг авч үзээд бид дараах тодорхойлолтыг гаргаж байна. Нутгийн аялгууны доторх буюу тухайн угсаатны доторх бүлгийн хүмүүсийн ярилцдаг хэл яриаг аман аялгуу гэнэ. Голдуу газар нутгийн байршил болон уг гарлаараа нэгдмэл байх бөгөөд авиа зүй, хэл зүй, үгийн сангийн хувьд тодорхой хэмжээгээр өөр өөрийн онцлогтой байх боловч тухайн нутгийн аялгууныхаа ерөнхий онцлогийг болон үндэстний хэлнийхээ нийтлэг шинжийг хадгалж, бичгийн хэлэндээ захирагдана.

Монгол хэлний халх, ойрад, буриад гурван нутгийн аялгуу нь дотроо дараах аман аялгуунуудтай. Үүнд:

Халх аялгуунд:

I. Улаанбаатарын аман аялгуу

II. Төв халх аман аялгуу

III. Баруун халх аман аялгуу

IV. Зүүн халх аман аялгуу

V. Халх-буриадын завсрын аман аялгуу байна.

Ойрад аялгуунд:

I. Умард ойрад аман аялгуу

II. Өмнөд ойрад аман аялгуу

III. Ойрад-халхын завсрын аман аялгуу

IV. Ойрад-халх-буриадын завсрын дархад аман аялгуу байна.

Буриад аялгуунд:

I. Хори-агын буриад аман аялгуу

II. Буриадажсан хонгоодор аман аялгуу

III. Буриад-халхын завсрын барга аман аялгуу байна.

Улаанбаатарын аман аялгууны тухайд: Монгол хэл шинжлэлийн бүтээлүүдэд “Утга зохиолын хэл нь тухайн ард түмний улс төр, соёл, шинжлэх ухааны бүх салбарт хэм тэгш үйлчилж байгаа дуун ухаан хэмээх хэл шинжлэлийн талаасаа боловсорч, харьцангуй тогтворжсон хэм хэмжээ бүхий хэл юм... Монголын орчин үеийн утга зохиолын хэлний суурь болсон аялгуу нь халх аялгуу юм” (Санжаа нар, [1993], 2010, 2018: 20, 25) гэх мэтээр тодорхойлж ирсэн боловч зөв дуудах зүй, зөв бичих зүйн хэм хэмжээг их төлөв Улаанбаатарынхны хэл ярианд тулгуурлан тогтоож, хэл шинжлэлийн бүтээлүүдийн дийлэнх нь тус хэл ярианд суурилсан байдаг. 2022 онд хэвлэгдсэн “Монгол хэл судлал” 15 боть бүтээлийн ‘Нутгийн аялгуу’ хэмээх VI ботид халх аялгууг тусгайлан судалсан Ц.Батдорж “Олон нутгийн аялгуу зэрэгцэн оршиж байгаад, соёлоор давамгайлсан угсаатны бүлгийн аялгуу нь уран зохиолын бүтээлд ашиглагдаж, илүү өргөн хүрээнд тархан хэрэглэгдэж, улмаар албан ёсны харилцааны хэл болж, түүнд суурилан ард түмнийг нэгтгэх үүрэгтэй бичгийн хэл бүрэлдэн тогтоно. Тийнхүү бичгийн хэл зөв дуудлага, зөв бичих ёс, найруулгын хэм хэмжээний хэв загвар болж, үгийн сангийн хэрэглээний үндсэн нөөц болсон нутгийн аялгууг *суурь аялгуу (standard dialect)* гэдэг. Түүхээс үзэхэд тухайн нийгмийнхээ улс төр, эдийн засаг, соёл боловсролын тогтолцооны төв болж буй хотын хэл яриаг суурь аялгуу болгох нь түгээмэл байдаг. Тухайлбал, орос хэл Москвагийн, франц хэл Парисын, англи хэл Лондоны, чех хэл Прагийн, япон хэл Токиогийн, хятад хэл Бээжингийн аялгуунд суурилжээ” (Батзаяа нар, 2022: 27) хэмээн тайлбарласан байна. Түүнчлэн, тус бүтээлийн ‘Авиа зүй’ хэмээх VIII ботид “Монгол Улсын нийслэл хотын хүн амын хэлийг *Улаанбаатарын хэл яриа (Ulaanbaatar speech)* гэж ойлгож болно... Тус бүтээл нь Улаанбаатарын хэл ярианд суурилсан *стандарт монгол хэлийг* гол судлагдахуунаа болгож байна. Стандарт хэл нь улс төр, нийгэм соёлын төв болсон газар өргөн хэрэглэгддэг, хэлний нэгдлийг бүрдүүлж чаддаг, боловсронгуй хэл байх ёстой. Өөрөөр хэлбэл, их, дээд, дунд сургуулийн багш нарын болон радио телевиз, сонин зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслийн хэл юм” (Уртнасан нар, 2022: 18-19) хэмээн ‘утга зохиолын хэл’ гэдэг нэр томъёог ‘стандарт монгол хэл’ гэсэн байна.

Анх Г.И.Рамстедт ‘Монгол бичгийн хэл ба халх-өргөөгийн аман аялгууны харьцуулсан авиа зүй’ хэмээх алдарт бүтээлдээ Өргөө хотын халхчуудын хэл ярианд суурилсан халх аялгууны тухай бичиж, түүнийгээ ‘говор’ (аман аялгуу) хэмээн нэрлэжээ (Рамстедт, 1908). Дараа нь Б.Я.Владимирцов ‘Монгол бичгийн хэл ба халх аман аялгууны харьцуулсан авиа зүй’ бүтээлдээ “Гадаад монгол тусгай улс болсон тэр цагаас халх аялгууны нэр хүнд улам нэмэгдсэн нь мэдээж. Ийм нөхцөл шалтгаанаас буюу ялангуяа улс үндэстний хэл болсон нэр хүндийнхээ хувьд хуучнаасаа халин давж, монгол хэлний бусад ойролцоо

аман аялгууг давамгайлж байна. Халх аялгуу ар монголын нийтийн хэл болох хандлагатай болж байгаа бөгөөд гэхдээ Өргөө-Улаанбаатар төвтэй халх хүрээний аман аялгуу ялан дэлгэрч байна” (Владимирцов, 1929: 49-50) гэжээ. Энд В.Я.Владимирцов ‘наречия’ (хэл яриа) гэдэг нэр томъёогоор ‘нутгийн аялгуу – аман аялгуу – салбар аман аялгуу’ (диалект-говор-подговор) гэсэн тогтолцооны алинд ч оруулалгүйгээр ерөнхийлөн нэрлэжээ. Орчин үед Ц.Батдорж (2022), Д.Заяабаатар (2022, 2023) нарын эрдэмтэд Улаанбаатарын хэл яриа (Ulaanbaatar speech)-г стандарт аялгуу (standart dialect) хэмээн тодорхойлж байна. Тухайлбал Ц.Батдорж, Д.Заяабаатар нар “Түүхээс үзэхэд, тухайн нийгмийнхээ улс төр, эдийн засаг, соёл боловсролын тогтолцооны төв болж буй хотын хэл яриаг суурь аялгуу болгох нь түгээмэл байдаг. Тухайлбал, орос хэл Москвагийн, франц хэл Парисын, англи хэл Лондоны, чех хэл Прагийн, япон хэл Токиогийн, хятад хэл Бээжингийн аялгуунд суурилжээ” (Батзаяа нар, 2022: 27) гээд “Бид монгол бичгийн хэлний суурь аялгууг халх гэж нэрлэхээс илүү олон улсын жишгээр нийслэл буюу төвлөрсөн газраар нь Улаанбаатар аялгуу гэж хэвшүүлэх саналтай байна. Монгол бичгийн хэлний суурь аялгууг Улаанбаатар аялгуу гэж нэрлэх нь зарим талаар хэл аялгууны тогтолцоот үзэгдлийг угсаатны ээдрээт асуудал болгон хувиргаж хутгадаг байдлаас ч зайлсхийх дувуу талтай. Улаанбаатар аялгууны зөв дуудах ёсны хэм хэмжээний гол шалгуур нь халх аялгууны дуудлагын тогтолцоо болно” (Пүрэвжав нар, 2022: 132-133) гэжээ.

2024 байдлаар Монгол Улсын нийт хүн ам (3544835)-ын 49.88% (1768151)⁹-ийг буюу хагасыг Улаанбаатар хотын хүн ам эзэлж байна. Тэд Монгол Улсын өнцөг булан бүрээс буюу нутгийн аялгуутан бүрээс нийслэл хотдоо ирж суурьшаад, 1639 оноос¹⁰ хойш тоолбол өдгөө цаад зах нь 385 жил буюу монгол хүний амьдралын 5 ба түүнээс олон үеийг¹¹ өнгөрөөжээ. Хөдөө орон нутгаас нийслэл хотруугаа нүүж ирж суурьших, нийслэлээс хөдөө нутагт нүүж суурьших явдал тасралтгүй үргэлжилсээр байна. Тиймээс ямар нэгэн аймаг, суманд бус Улаанбаатар хотод төрж өссөн, хэлд орсон, сурч хүмүүжсэн, уг хотдоо насаараа юм уу хэдэн үеэрээ амьдарсан, чухам Улаанбаатар хотын хэл яриагаар хэлд орж, түүгээрээ ярьдаг хүн амын тоо монголчуудын дотор багагүй хувийг эзлэх болжээ. Тэдний хэл яриа нь ойрад, буриад нутгийн аялгуунаас ялгаатай буюу үндсэндээ халхажсан, улмаар Төв, Архангай, Өвөрхангай, Баянхонгор зэрэг аймагт төвлөрөн суурьшсан төв халхчуудын хэл ярианаас тодорхой, цөөвтөр боловч ялгаатай. Тухайлбал дурдсан аймгуудын төв халхчууд [qot^h] – *хот*, [qats^her] – *хацар*, [ʃixəɣ] – *чихэр*, [tsɛts^hək] – *цэцэг*, [tɔs] – *тос*, [taxt^ha:] – *тагтаа* гэх мэтээр үгийн эхэнд тохиолдох дуугүй чанга [x/χ], [ʃ^h], [ts^h], [t^h] гийгүүлэгчүүдийг дэд

⁹ Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. Үндэсний статистикийн хороо.

¹⁰ 1639 онд [Ширээт цагаан нуурт Өндөр гэгээнийг](#) залж орд өргөө босгосноор Улаанбаатар хотын өмнөх суурин байгуулагджээ. 1778 он хүртэл олон газар нүүдэллэж байгаад одоогийн байрлалдаа тогтсон байна.

¹¹ 2022 оны байдлаар монгол хүний дундаж наслалт 71.3 байна (Үндэсний статистикийн хороо). Энэ тоогоор тооцвол 385 жил нь таван үе болох бөгөөд айл болж, хүүхэд төрүүлэх насаар тооцвол түүнээс олон үе болох юм.

үеийн эхэнд орсон чанга гийгүүлэгчээс нь ондоошуулж, амьсгалын түрэлтгүй болгон сулруулж [k/q], [ʃ], [ts], [t] гэж хэлэх нь түгээмэл байдаг. Мөн [ʃʒrʃhəm] – *зарчим*, [ʃʒnʃəl] – *занишил*, [ʃhɑ:ʃ~ʃhʒ:ʃ] – *цааши*, [ʃʌʃək] – *сүсэг*, [ʃʒʃtər] – *шастир* гэх мэтээр үгийн эхний шүд-түүшний [ts], [tsʰ], [s] гийгүүлэгчүүдийг дэд үед орсон түүш-тагнайн [ʃ], [ʃh], [ʃ] гийгүүлэгчүүдтэй ижилсүүлж ярьдаг. Тэгвэл Улаанбаатарынхан тэгж ярьдаггүй, тухайн гийгүүлэгчийг үндсэн өнгөөр нь хэлдэг. Мөн Улаанбаатарынхан [pit] – *бид* гэж хэлдэг үгийг төв халхчууд [pʲat] гэж ярих нь бий. [awtərtɑ:r] – *авдар дээр*, [ɔrəntɔ:r] – *орон дээр* гэж өмнөх үгтэйгээ эгшгээр зохицсон орших тийн ялгалын нөхцөл төв халх болон бусад аялгуунд үүсэн бүрэлдэж байгаа бол Улаанбаатарынхан [awtər te:r] – *авдар дээр*, [ɔrən te:r] – *орон дээр* гэх мэтчилэн [te:r] гэж өмнөх үгтэй нь зохицуулахгүйгээр ярьдаг. Эзэнд хамаатуулах нөхцөлийг төв халхчууд [mɔɛrɔ:ŋ ɔnɑ:t] – *морио унаад*, [ur xɪ:xɪ:xe:n tʰɵlɵ:] – *үр хүүхдийнхээ төлөө* гэх мэтчилэн эцсийн [ŋ] гийгүүлэгчийг хасахгүйгээр хэлэх нь түгээмэл байхад Улаанбаатарынхан [mɔɛrɔ: ɔnɑ:t], [ur xɪ:xɪ:xe:n tʰɵlɵ:] гэж хасаж хэлдэг. Ийнхүү, Улаанбаатарын хүмүүс их төлөв кирилл бичгийн хэлтэйгээ маш ойрхон ярьдаг онцлогтой. Гэхдээ яг тохирдог гэж ойлгож болохгүй (Бичгийн хэлтэйгээ зуун хувь тохирдог хэл хаана ч байхгүй). Дээрх тодорхойлолтын үүднээс авч үзвэл орчин цагийн монгол хэлний халх аялгуун дотор ийм шинж бүхий, газар нутгийн байршлаараа нэгдсэн ‘Улаанбаатарын аман аялгуу’ хэмээх нэгэн ангилал үүсэн төлөвшсөн бөгөөд тэр нь монгол хэлний *суурь аялгуу (standard dialect)* болж байна.

Халх нутгийн аялгуу нь Улаанбаатарын аман аялгуунаас гадна төв халх, баруун халх, зүүн халх болон халх-буриадын завсрын аман аялгуунуудтай. Ойрад нутгийн аялгуу нь умард ойрад, өмнөд ойрад ба ойрад-халхын завсрын, ойрад-халх-буриадын завсрын ба монголжсон¹² аман аялгуунуудтай. Буриад нутгийн аялгуу нь хори-агын буриад, буриадажсан хонгоодор¹³, буриад-халхын завсрын барга аман аялгуутай. Тэдгээр нь газар нутгийн байршил, угсаатны бүлгээрээ нэгдэж, өөр хоорондоо авиа зүй, хэл зүй, үгийн сангийн түвшинд тодорхой хэмжээгээр ялгарахын зэрэгцээ тухайн нутгийн аялгууныхаа нийтлэг шинжийг хадгалдаг.

1.5. Салбар аман аялгуу (Подговор - Branch of subdialect)

¹² Хөвсгөл аймгийн цөөн сумд болон Баян-Өлгий аймгийн нутгаар тархан суурьшсан мончоого, соёд-цаатан, тува, хасаг хүмүүс монголжихдоо монгол хэлний ойрад аялгуугаар ярьдаг болжээ.

¹³ Эрт цагт Хонгоодор болон Хотгойдууд Ойрадын зүүн хойд аймгууд байжээ. Хонгоодорууд 1688 оны ойрад халхын дайнаас дүрвэж, Хөвсгөл нуурын зүүн хойд Байгал нуурын баруун талаарх буриад зонтой нийлжээ. 1911 оны үеэс Монгол руу чиглэсэн нүүдлийн дотор Буриад Улсын Түнхэн аймгаас ирсэн буриадууд, дараа нь Захаамин аймгийн Санага тосгоноос буриадууд ирж, дээрх нутагт суурьшжээ. Ийнхүү тэд ойрад, буриадын нийлмэл овог бөгөөд өнөөг хүртэл түүхийн урт хугацаанд (наад зах нь 300 гаруй жил) буриад угсаатанд улам бүр уусан нэгдсэн зон юм. Өдгөө буриад аялгууны нэгэн аман аялгуугаар ярьдаг. Иймээс монгол хэлний нутгийн аялгууны өмнөх хуваарилалтад “Түнхэн санагын буриад” гэж байсныг бид овог угсаагаар нь ‘Буриадажсан хонгоодор’ хэмээн нэрлэж, буриад аялгууны нэг аман аялгуу гэж үзэж байна (Батзаяа нар, 2025: 454-459).

Салбар аман аялгууг орос хэлээр “подговор” гэдэг. Харин англи хэлээр ийм ангиллыг авч үздэггүй. Академич Ш.Лувсанвандан “Нэгэн аман аялгууны дотор багтавч хааяа авиа зүй, үгсийн сангийнхаа талаар гол олонхоосоо өчүүхэн ялгарах нэг нутгийн бүлэг хүмүүсийн үг хэлийг салбар аман аялгуу гэж нэрлэв” (Лувсанвандан, [1959] 2002: 36-55) гэжээ. Сүүлийн үед нутгийн аялгуу судлаач Ц.Батдорж “Аман аялгуу нь дотроо тухайн нутгийн онцлог бүхий, угсаатны бүлэгт суурилсан салбар аман аялгуунд хуваагдаж болно” (Батзаяа нар, 2022: 28) гэсэн байна. Эдгээрийг нэгтгээд бид дараах байдлаар тодорхойлж байна. Аман аялгууны доторх, өөр хоорондоо багахан хэмжээгээр ялгарах, бүлэг хүмүүсийн ярилцдаг хэл яриаг салбар аман аялгуу гэнэ. Голдуу угсаатны доторх омог удам, оршин суугаа нутаг ус зэргээр нэгэн бүлэг болсон, авиа зүй, хэл зүй, үгийн сангийн хувьд бага хэмжээний тодорхой онцлогтой боловч тухайн аман аялгуу, нутгийн аялгууныхаа ерөнхий онцлогийг болон үндэстний хэлнийхээ нийтлэг шинжийг хадгалж, бичгийн хэлэндээ захирагдана. Ийм шинж бүхий аялгуунууд орчин цагийн монгол хэлэнд байгаа учраас ийм нэр томъёо монгол хэлний нутгийн аялгуу судлалд зайлшгүй хэрэгтэй байна. Салбар аман аялгуу гэдэг нэр томъёог англи хэлээр *branch of subdialect* хэмээн орчуулж болох юм.

Дээр дурдсан ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэмтэд хамтран, өнөөгийн бодит байдлыг судалж бичсэн “Монгол хэлний нутгийн аялгууны судалгаа” хэмээх бүтээлдээ бид монгол хэлний нутгийн аялгуу, аман аялгуунууд доторх салбар аман аялгуунуудыг дараах байдлаар ангилж, суурышин амьдарч буй газар нутгийг тоочин бичиж, газрын зурагт тэмдэглэсэн юм. Үүнд:

Нэг. Халх нутгийн аялгуу:

I. Улаанбаатарын аман аялгуу: Улаанбаатар хотын хүн ам

II. Төв халх аман аялгуу

1. Төв халх салбар аман аялгуу

Баянхонгор, Орхон аймгийн нийт хүн ам, Төв, Архангай, Өвөрхангай, Булган аймгийн олонх сум, Сэлэнгэ аймгийн талаас илүү хувь

2. Өвөрхангайн халх салбар аман аялгуу

Өвөрхангай аймгийн Уянга, Бат-Өлзий, Өлзийт, Зүүнбаян-Улаан, Тарагт сумдын хүн ам

3. Говийн халх салбар аман аялгуу

Өмнөговь, Дундговь, Дорноговь, Говьсүмбэр аймгийн хүн ам

III. Баруун халх аман аялгуу

4. Өрнөд халх салбар аман аялгуу

Говь-Алтай аймгийн нийт хүн ам, Завхан аймгийн зүүн сумдын хүн ам, Ховд аймгийн Ховд, Буянт сумдын хүн ам

5. Элжигин халх аман аялгуу

Увс аймгийн Өндөрхангай, Зүүнхангай, Цагаанхайрхан сумдын нийт хүн

ам, Баруунтуруун сумын хүн амын хагас нь.

6. Сартуул салбар аман аялгуу

Завхан аймгийн Алдархаан, Дөрвөлжин, Ургамал, Завханмандал, Сантмаргаз, Сонгино, Цэцэн-Уул, Эрдэнэхайрхан, Түдэвтэй сдумын нийт хүн ам. Завхан аймгийн Баянхайрхан, Ховд аймгийн Чандмань сум, Увс аймгийн Завхан суманд цөөн цөөнөөр.

IV. Зүүн халх аман аялгуу

7. Дорнод халх салбар аман аялгуу

Хэнтий, Дорнод аймгийн хойд сумдаас бусад, Сүхбаатар аймгийн өмнөд сумдаас бусад олонх сумын хүн ам

8. Дарьганга салбар аман аялгуу

Сүхбаатар аймгийн Уулбаян, Хадаан, Түвшинширээ, Баяндэлгэр, Асгат, Дарьганга, Наран, Онгон сумдын хүн ам.

9. Халхажсан өвөр монгол салбар аман аялгуу

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан суманд төвлөрөн, Дорнод аймгийн Сэргэлэн, Баянтүмэн, Булган, Хэрлэн сумдад цөөн цөөнөөр халхажсан үзэмчин, цахар.

Өмнөговь аймгийн Ноён, Гурвантэс, Сэврээ, Баяндалай, Булган, Мандал-Овоо, Цогтцэций, Ханбогд сумд, Дундговь аймгийн Дэлгэрхаан, Луус сумд, Дорноговь аймгийн Хатанбулаг, Хөвсгөл, Алтанширээ сумдад хэсэг бусгаар халхажсан харчин.

V. Халх-буриадын завсрын аман аялгуу

10. Цонгоол салбар аман аялгуу

Сэлэнгэ аймгийн Ерөө, Алтанбулаг сумдад төвлөрөн, Сүхбаатар, Хүдэр, Шаамар, Жавхлант сумд, Дорнод аймгийн Баян-Уул, Баяндун сумд, Хэнтий аймгийн Биндэр, Дадал, Батширээт сумдад цөөн цөөнөөр.

11. Монголжсон хамниган салбар аман аялгуу

Дорнод аймгийн Цагаан-Овоо, Баян-Уул, Баяндун, Дашбалбар, Булган, Баянтүмэн, Чулуунхороот сумд; Хэнтий аймгийн Дадал, Норовлин сумд, Сэлэнгэ аймгийн Ерөө суманд хэсэг бусгаар оршин сууна.

Хоёр. Ойрад нутгийн аялгуу:

I. Умард ойрадын аман аялгуу:

1. Дөрвөд (болон дөрвөдөжсөн хотон) аман аялгуу

Увс аймгийн Давст, Сагил, Бөхмөрөн, Түргэн, Улаангом, Ховд, Өмнөговь, Өлгий суманд төвлөрнө. Наранбулаг, Баруунтуруун сумд, Ховд аймгийн Мянгад, Дөргөн сумд, Баян-Өлгий аймгийн Ногооннуур, Цэнгэл сумд, Сэлэнгэ аймгийн Хүдэр, Ерөө сумдад цөөн. Хотон нь Увс аймгийн Тариалан сум, Наранбулаг сумын хагас, Сагил, Тэс сумдад цөөн.

2. Баяд салбар аман аялгуу
Увс аймгийн Тэс, Зүүнговь, Малчин, Хяргас сумдад төвлөрнө.
Наранбулаг сумын хагас.
- II. Өмнөд ойрад аман аялгуу:
 3. Урианхай салбар аман аялгуу
Алтайн урианхай: Ховд аймгийн Ховд, Дуут, Мөнххайрхан сумдад төвлөрнө. Ховд аймгийн Мөст, Баян-Өлгий аймгийн Өлгий, Алтай, Сагсай, Буянт, Алтанцөгц, Булган, Бугат, Дэлүүн судад цөөн цөөнөөр.
Ариг урианхай: Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр суманд төвлөрөн, Баян-Өлгий аймгийн Алтай, сагсай, Буянт, Алтанцөгц, Бугат, Булган сумд, Говь-Алтай аймгийн Тонхил сум, Ховд аймгийн Цэцэг, Дарви сумдад цөөн цөөнөөр.
 4. Өөлд салбар аман аялгуу
Ховд аймгийн Эрдэнэбүрэн суманд төвлөрнө. Архангай аймгийн Өлзийт сум болон Батцэнгэл, Хашаат, Өгийнуур, Хотонт сумдад цөөн.
 5. Торгууд, хошууд салбар аман аялгуу
Торгууд нь Ховд аймгийн Булган сумын хагас нь торгууд, хагас нь хошууд.
 6. Захчин салбар аман аялгуу
Ховд аймгийн Манхан, Зэрэг, Үенч, Алтай сумдад төвлөрнө. Мөст сумын хагас, Ховд хотод цөөн.
- III. Ойрад-халхын завсрын аман аялгуу:
 7. Мянгад салбар аман аялгуу
Ховд аймгийн Мянгад суманд төвлөрнө. Увс аймгийн Өлгий, Өмнөговь сумдад цөөн.
 8. Хотгойд салбар аман аялгуу
Хөвсгөл аймгийн Цэцэрлэг, Цагаан-Уул, Бүрэнтогтох сумдад төвлөрөн, Шинэ-Идэр, Төмөрбулаг, Арбулаг, Тосонцэнгэл сумд, Завхан аймгийн Завхан, Нөмрөг, Тэлмэн, Баянтэс, Тэс, Баянхайрхан, Их-Уул, Идэр сумдад цөөн цөөнөөр.
- IV. Ойрад-халх-буриадын завсрын аман аялгуу: дархад
Хөвсгөл аймгийн Баянзүрх, Улаан-Уул, Ринчинлхүмбэ, Цагааннуур сумдад төвлөрөн, Арбулаг, Алаг-Эрдэнэ, Ханх сумдад цөөн.
- V. Монголжсон аман аялгуу:
 9. Монголжсон мончоого, соёд, тува салбар аман аялгуу
Хөвсгөл аймгийн Цагааннуур, Ринчинлхүмбэ сумдад цөөн цаатан. Баян-Өлгий аймгийн Цэнгэл, Алтай, Сагсай сумд, Ховд аймгийн Буянт суманд мончоого ба соёд урианхай.

10. Монголжсон хасаг салбар аман аялгуу:

Баян-Өлгий аймгийн Цэнгэл, Улаанхус, Өлгий, Толбо, Дэлүүн, Баяннуур, Ногооннуур сумдад төвлөрнө. Сагсай, Алтай, Буянт, Бугат, Булган, Алтанцөгц сумдын зарим нутагт байна.

Гурав. Буриад нутгийн аялгуу:

I. Хори-агын буриад аман аялгуу

1. Хорийн буриад салбар аман аялгуу

Хэнтий аймгийн Батширээт, Биндэр, Дадал, Норовлин сумдад төвлөрөн, Дорнод аймгийн Цагаан-Овоо, Баян-Уул, Дашбалбар сумд, Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сум, Сэлэнгэ аймгийн Ерөө, Зүүнхараа сумд, Төв аймгийн Мөнгөнморьт сумд цөөн цөөнөөр.

2. Агын буриад салбар аман аялгуу

Дорнод аймгийн Цагаан-Овоо, Баян-Уул, Баяндун, Дашбалбар сумдад төвлөрөн, Хэрлэн, Хөлөнбуйр, Гурванзагал, Чулуунхороот сумдад цөөнх.

II. Буриадажсан аман аялгуу: хонгоодор

Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр, Ханх, Эрдэнэбулган сумд, Булган аймгийн Тэшиг сумд төвлөрөн, Хөвсгөл аймгийн Мөрөн, Алаг-Эрдэнэ, Хатгал сумд, Сэлэнгэ аймгийн Ерөө, Зүүнхараа сумдад цөөн цөөнөөр.

III. Буриад-халхын завсрын аман аялгуу: барга

Дорнод аймгийн Хөлөнбуйр, Гурванзагал сум, Төв аймгийн Сэргэлэн сумд төвлөрөн, Дорнод аймгийн Баяндун, Баянтүмэн, Чойбалсан, Чулуунхороот сумд, Төв аймгийн Баянцагаан, Баян сумд, Хэнтий аймгийн Өмнөдэлгэр суманд цөөн.

Тухайлбал, Өвөрхангайн халх салбар аман аялгуу. Авиа зүйн хувьд: Үе, үгийн эцэст [k/ʏ] гийгүүлэгчийг [q/ʏ]-аар [tsʰaq] – *цаг*, [notʰɪ:ŋ xuŋ] – *нутгийн хүн* гэх мэтчилэн хэлдэг. Харин [ajək] – *аяга* гэх мэтчилэн цөөн үгэнд [q/ʏ] гийгүүлэгчийг [k/ʏ]-аар хэлдэг. Өгүүлэгч тодорхой баймж утга илэрхийлэхдээ урт эгшгийг зориуд сунган, дунд нь түр зогсосхийж [xule:ʏe-e:ɪ so:n] – *хүлээгээд л сууна* гэх мэтчилэн хэлдэг. Мөн *суу-а* гэх мэт зарим үг төв халхад [soq] гэж урт эгшиггүй байхад өвөрхангайн халхад [so:] гэж урт эгшигтэй, төв халхад [ta:wo:] – *даавуу* гэдэг үгийг [ta:w] – *даавуу* гэж эцсийн эгшгийг гэж хэлдэг. Хэл зүйн хувьд: олон тоот нэр үг бүтээх *-ынхан/-ийнхэн*, *-ыхан/-ийхэн* гэдэг нийлмэл бүтээврийг [manʒxĩŋ] – *манайхан*, [xɔtʰɪ:ŋxĩŋ] – *хотынхон* гэх мэтээр ямар ч үгэнд хүүхэн хэлний [χ] гийгүүлэгчээр хэлэхгүй, ямагт зөөлөн тагнайн [x] гийгүүлэгчээр хэлдэг. Мөн харьяалахын тийн ялгалын дараа гуравдугаар биед болон эзэнд хамаатуулах нөхцөл залгахдаа жийрэглэдэг гийгүүлэгчийг [qal qɔlɛmtʰɪ:ŋxe:] – *гал голомтынхоо*, [malɪ:ŋxe:] – *малынхаа*, [qal qɔlɛmtʰɪ:xĩn] – *гарных нь*, [malɪ:xĩn] – *малынх нь* гэх мэтээр ямар ч үгэнд зөөлөн тагнайн [x]-ээр хэлдэг. Үйл үгийн гуравдугаар биед зөвшин захирах *-г* нөхцөлийг өмнө нь урт эгшигтэйгээр

унтаг [ontʰi:k] *хөөрхий*, *эцээхэн амраад аваг* [awi:k] гэх мэтээр хэлдэг. Төв халх аялгуунд тэмдэг нэрийн эхний задгай үеийг [w] гийгүүлэгчээр хааж уг тэмдэг нэрийн үндсэнд угтуулан эрчимжүүлдгийг өвөрхангайн халх салбар аман аялгуунд [p] гийгүүлэгчээр хааж хэлдэг. Жишээ нь: [хар хар, хор хо:гж:, ор ол:н] гэх мэт. Мөн [pu: met] – *буу мэд* гэж хэлдгийг [po: met] гэж [o:] эгшгээр хэлдэг. Үгийн сангийн хувьд: [a:ʃy:] – *аашгүй (ааш муутай, муухай зантай)*, [etʰe:хэн] – *эцээхэн (сайн, олигтой, зэгсэн)* гэх мэт цөөн өвөрмөц үг бий.

Баяд салбар аман аялгуу: Ойрадын голлох дөрвөд салбар аман аялгуунаас [œ], [y] эгшигтэй, үгийн тэргүүн бус үед [a]~[ɔ], [a:]~[ɔ:] сэлгэдэг, цөөн хэдэн өвөрмөц үг төдийгөөр буюу бага зэрэг ялгарна. Жишээ нь: дөрвөдөд [tʰш:ry:] – *тойруу*, [py:t] – *буйд*, [ɔta:] – *одоо*, [ɔta:kʰ] – *одоох (нөгөөх)*, [ɔrān] – *орон*, [nɔxa:] – *нохой* гэх мэтээр ярьдаг бол баядад [tʰœ:ro:], [py:t], [ɔta:~ɔtɔ:], [ɔta:kʰ~ɔtɔ:kʰ], [ɔrān~ɔrɔn], [nɔxa:~nɔxɔ:] гэх мэтээр сэлгэж ярьдаг. Үйлийн бүрмөсөн үйлдэх байдлын нөхцөлийг ойрадын зарим салбар аман аялгуунд эр-чанга, эм-хөндий ямар ч үгэнд [-ʃʰэх] гэж хүүхэн хэлний [χ]-ээр хэлдэг бол баядад ямар ч үгэнд [-ʃʰэх] гэж зөөлөн тагнайн [χ]-ээр хэлдэг. Дээлийн энгэрийн ухлаадсыг [tʰshxtʰ] – *цөгц*, захыг [mants] – *манз*, эмжээрийг [tʰasəm] – *тасам*, бүсний арлыг [qɔnrɪk] – *гонриг*, эмээлийн хатавчийг [atʰəфʃʰ] – *атавч*, гөлмийг [kʰiʃim] – *кижим* гэнэ. Бас [qakəltəx] – *галгалзах (ангалзах, аальгүйтэх)*, [nyrəx] – *нүрэх (шөргөөх)*, [yʷəwɔ:ləx] – *уливрлуулах (эргүүлэх)*, [kʰy:rsəx] – *хүүрсэх (ярилцах)* гэх мэт үг байна.

Хори буриад салбар аман аялгуу: Богино [ə] эгшиг нь халх аялгууныхаас хойгуур, эр чанга [ɭi:] эгшигтэй, [ə] эгшгийн байранд [u] хэлдэг, [ts], [tʰ], [ʃ], [ʃʰ] гийгүүлэгчийн байранд сул шүргэх ба шүргэх [z], [s], [ʒ], [ʃ] хэлдэг, [s] гийгүүлэгчийн байранд [h] хэлдэг, [q], [k], [t], [p], [ʃ]-ийн байранд сул дуутай [g], [g], [d], [b], [l] хэлдэг ([zɔŋ] – *зон*, [seseg] – *цэцэг*, [ʒarʒal] – *жаргал*, [ʃamaha:] – *чамаас* гэх мэт), монгол хэл, аялгуунуудын дотроос эгшгийн балархайшилт хамгийн бага, заах (-i:je/-i:je/-je), гарахын тийн ялгал (ha:/-he:/-hɔ:/-hə:) нь онцлог, бие заах нөхцөлтэй (pi аβхаβ, pide аβхаβdi, ʃi аβi:ʃ, tʰa аβi:tʰ) гэх мэт буриад аялгууны үндсэн шинжийг хадгалдаг. Гэхдээ агын буриаднуудыг бодвол арай илүү халхжиж, хэрэглээ нь багасан, зарим шинж нь бүдгэрч байна.

Энэ мэтээр салбар аман аялгуу тус бүр тухайн нутгийн аялгууныхаа голлох болон бусад салбар аман аялгуунаас тодорхой цөөн ялгаатай.

1.6. Завсрын аман аялгуу (Промежуточный говор - Intercurrent subdialect)

Аялгуунуудын ялгаа зааг буюу ялгарах өвөрмөц онцлог шинжийг аялгууны зааг гэдэг. Гэтэл зарим аялгууг тодорхой зааглахад төвөгтэй буюу завсрын шинж үүссэн байдаг. Энэ ойлголтыг анх академич Ш.Лувсанвандан “Хөхнуур, Эзнээ гол, Алшаагийн монголчуудын үг хэл нь гарлаараа ойрад аялгуу боловч одоо төв аялгуу руу хэлбийж, завсрын аман аялгуу болжээ. Орчин цагийн монгол хэлний

завсрын аман аялгуунуудыг ажиглавал,... зах хязгаарынхаа аль нэг аялгуутай хутгалдсан байдалтай ажээ... Жишээлбэл, төв ба умард аялгууны завсрын аман аялгуу болох Сэлэнгийн аман аялгуу нь авианыхаа системээр халхын аман аялгуутай бараг адил боловч үгсийнхээ сангийн талаар буриад аялгуутай нэлээд ойролцоо. Мөн баргын аман аялгуу нь авианыхаа системээр умард аялгуутай төсөөтэй зүйл үзэгдэвч үгсийнхээ сангийн талаар халхын аман аялгуутай маш ойрхон болсон байна” (Ш.Лувсанвандан, [1959] 2002: 53) хэмээн тайлбарласан байдаг. Бид энэхүү тайлбарт үндэслэн, монгол хэлний нутгийн аялгуунуудын доторх аман аялгуунуудыг судалж үзээд, дараах байдлаар тодорхойлж байна. Өөр угсаа гарвалтай, өөр аялгуу байсан нь тодорхой, өөрийн аялгууны гол үндсэн шинжийг хадгалсан боловч нэгэн нутагт олон жил хамт суурьшсан аялгуутныхаа хэл яриа, зан заншил, ахуй соёлд нэлээд ойртон адилссан бол завсрын аман аялгуу гэнэ. Тэр нь хоёр аялгууны аль алины нь онцлогийг авиа зүй, хэл зүй, үгийн сангийн түвшинд илэрхийлэх бөгөөд оршин буй үндэстнийхээ хэлний нийтлэг шинжийг хадгалж, бичгийн хэлэндээ захирагдана. Ийм шинж бүхий аялгуунууд орчин цагийн монгол хэлэнд байгаа учраас ийм нэр томьёо монгол хэлний нутгийн аялгуу судлалд зайлшгүй хэрэгтэй байна. Энэ нэр томьёог орос хэлээр *промежуточный говор*, англи хэлээр *intercurrent subdialect* хэмээн орчуулж болох юм.

Монгол хэлэнд халх-буриадын завсрын цонгоол, монголжсон хамниган; буриад-халхын завсрын барга; ойрад-халхын завсрын мянгад, хотгойд; ойрад-халх-буриадын завсрын дархад аман аялгуу бий.

Цонгоол нь халхаас, монголжсон хамниган нь эвенк хэлтнээс гаралтай бөгөөд буриадуудтай хэдэн зуун жил айлсан, холилдон амьдарч, буриад аялгууны онцлогийг зохих хэмжээгээр хүртсэн боловч халх аялгууны шинжийг нэлээд хэмжээгээр хадгалж байна. Цонгоол аман аялгуунд: буриад аялгууны нэн тэргүүний онцлог шинж болох, бусад аялгууны хамжин шүргэх [ts], [ʧ], [tsʰ], [ʧʰ] гийгүүлэгчийн байранд хэлдэг сул шүргэх [z], [ʒ], шүргэх [s], [ʃ] болон төвөнхийн [h] гийгүүлэгч, гарахын тийн ялгалын [ha:] нөхцөл зэрэг нь байдаггүй. [h] гийгүүлэгч хэлдэггүй ч жишээлбэл халх аялгуунд ‘сөнөх’ гэж хэлдгийг буриадад ‘һүнэхэ’ гэж хэлдэг бол цонгоолд ‘хүнэхэ’ гэж эхний гийгүүлэгчийг буриадын [h]-ээр биш, халхын [x]-ээр хэлдэг. Үүнээс, олон жил буриадуудтай хамт нутаглаж ирсний хувьд буриадажсан боловч халх аялгууныхаа шинжийг зарим талаар огт алдаагүй, тухайлбал өгүүлүүрийн бааз нь буриад аялгууны [h] гийгүүлэгчийг хэлэхэд ижилсэн уусаагүй нь харагдана. Түүнээс гадна цонгоолд халх, буриадын алинд ч байдаггүй [øi] хос эгшигтэй, үгийн тэргүүн бус үедээ богино [ø] эгшгийг тод хэлдэг зэрэг өөрийн гэсэн өвөрмөц шинжүүд бий. Сэлэнгэ аймгийн цонгоолчууд халхчуудын дунд сууж, бараг бүрэн халхаар ярьдаг болсон бол Хэнтий, Дорнод аймгийн хори-агын буриадуудын дунд суурьшсан цонгоолчууд харьцангуй буриаджуу ярьдаг.

Монголжсон хамниган аман аялгууг академич Б.Ринчен “Монгол ард улсын хамниган аялгуу” бүтээлийнхээ ‘Дундад эртний монгол аялгууны үлдэгтэй хамниган аялгуу’ хэмээх хэсэгт “Өдгөө бүхүй хамниган, монголын дунд цөөн тооны хүмүүс суух тул эх хэлээ мартаж, монгол халхын хэлтэй болсон ба... ахмад насны хамниганы нэгэн хэсэг нь орчин хавийн монголчуудаас баахан өөр татлагатай аман аялгуугаар хэлэлцдэг... хамнигацуул түүнээ ‘хамниган аялгуу’ гэж нэрлэдэг байна. Гэтэл нарийвчлан үзвээс тэр нь хамниган аялгуу биш, хамнигацуулын аманд үлдсэн монгол аман аялгууны зүйл байнам. Түүний онцлогийг дурдвал худам монгол бичгийн зүйлд тэмдэглэдэггүй бөгөөд Монголын нууц товчоо, дөрвөлжин үсгийн гэрч бүхүй үгэнд төвөнгийн шүргэх гийгүүлэгч нь наашилж, хэлний угийн шүргэх х гийгүүлэгч болсон ану бас үзэгднэм” (Ринчен, 1969: 12, 81) хэмээн дүгнэжээ. Сүүлийн үед Ю.Янхунен “Монгол хэлнүүд” бүтээлдээ “Хамниганы монгол хэлийг өөр ямар ч монгол хэлний аялгуу гэж үзэж болохгүй... монгол хэл нь хамниганчуудын зонхилох олон нийтийн хэл бол хамниган эвенк хэлийг зөвхөн гэр бүлийн хүрээнд ашигладаг” (Янхунен, 2003: 83) гэжээ. Өдгөө тэд үндсэндээ халхажсан бөгөөд тодорхой үлдсэн онцлог гэвэл: ‘х’ гийгүүлэгчийг эр чанга үгэнд [q^h], эм сул үгэнд [k^h] гэж чанга хамжиж хэлдэг. Гагцхүү нутаг ус болон үгийн сангийн цөөнгүй хувь нь буриад аялгуутантай ижилссэн байна.

Харин барга аман аялгуутан нь угтаа буриадын өвөг дээдэс боловч өдгөө хэл аялгууны хувьд нэлээд халхажсан хүмүүс юм. Өдгөө цөөн тооны өвгөд хөгшид нь барга үг хэллэгээ мэддэг боловч өдөр тутамдаа халх аялгуугаар ярьж байна. Гэвч авиа зүй, хэл зүйн түвшинд цөөхөн онцлог хадгалагдан үлдсэн байна. Тухайлбал, бичгийн хэлний ‘ай, ой, уй’ зэрэг эгшгийг [i:] урт эгшгээр хэлдэг ([χɔ:lɪ:] – *хоолой* гэх мэт), тиймээс тэмдэг нэр бүтээх *-тай* дагавар, хамтрахын тийн ялгалын *-тай* нөхцөл, зөвлөн захирах *-аарай* нөхцөл зэргийг [-t^hi:] ([bɔdlɔkt^hi: xun] – *бодлоготой хүн*, [oχa:nt^hi: бжχ] – *ухаантай байх*), [-a:ɾi:/-ɔ:ɾi:] ([somān ɛnɔ:ɾi:] – *сум нь оноорой*, [mɛɣʊn t^hɔda:ɾi:] – *мэргэн тусаарай*) гэх мэтчилэн хэлдгээрээ монгол хэлний бусад аялгуунаас ялгардаг. Мөн үгийн санд нь буриадтай адилхан хэлдэг үгс олон, буриадаас өөр, зөвхөн барга аялгуунд хэлдэг үгс ч цөөвтөр байдаг.

Мянгад, хотгойд нь ойрад гаралтай боловч халх аялгууны нөлөөлөнд орж, халх аялгууны шинжийг хүртсэн атлаа ойрад аялгууныхаа шинжийг бас зарим талаар алдаагүй байна. “Мянгад аялгууны баримтаас үзвэл энэ аялгуунд ойрад, халх аялгуу хольцолдсон боловч ойрад аялгууны шинж давамгайл байна” (Цэндээ, 2012: 54). Тухайлбал: [e:ɾɛʈ^hж:] – *эрэгтэй*, [e:mɛʈ^hж:] – *эмэгтэй* гэх мэтээр зарим үгэнд эцсийн задгай үеийн урт эгшгийг уужимсуулж ярих боловч зарим үгэнд [pɔ:lɔɔ:] – *боолгоо*, [k^hʃwʃ:] – *хөвөө*, [sere:] – *сэрээ*, [yʊ^he:x] – *үгтээх* гэх мэтчилэн халх шиг эгшгээр ижилсэн зохицдог. Мянгад, хотгойдод: [mɔɛɣ] – *морь*, [sɔɛŋkɛn] – *сонгино*, [pɣ:t] – *буйд* гэх мэтээр халх шиг [œ], [y] эгшигтэй. Хэл зүйн хувьд үйл үгийн дагалдах хэлбэрийн *-хлаар/-хлээр* нөхцөлийг халхын аман ярианд хэлдэгтэй төстэй [-χ^ha:ɾ/-χ^hж:ɾ], хоёрдугаар биед хүндэтгэх *-гтун/-гтүн*

нөхцөлийг халх, ойрадын аль алинаас өөрөөр [-xt^ho:/-xt^hy:] гэж хэлдэг. Жишээ нь: [so:xt^ho:] – *суугтуу/суугтун/*, [mж:xt^ho:] – *майгтуу/майгтун – май, авагтун/*, [irəxt^hy:] – *ирэгтүү/ирэгтүн/*. Ойрадын олонх аялгуунд нэгдүгээр биеийн төлөөний үгийг [mans], [ma:ns], [ma:no:s] гэж хэлдэг бол мянгад, хотгойдод [pit], [pitən], [pitny:s] гэж хэлдэг. Үгийн сангийн хувьд: [pilʃʃigvān] – *билжирган (голио)*, [awa:tʃʃ] – *аваалж (аалз)*, [santʃa:] – *санзаа (хэвийн боов)*, [χawχo:rʃʃa:] – *хавхууржаа* (үнсний хамуур) гэх мэт цөөн өвөрмөц үг бий.

Ж.Цолоо “Хотгойд аман аялгуунд алтайн урианхай, захчин, торгууд зэрэг аман аялгуунд байдаг хэлний урдуурх бүр урагшилсан *аэ*, урт *аэ*, *ү*, урт *ү*-г бодвол хагас урагшилсан хэлний дунд этгээдийн *ае*, урт *ае*, *ү*, урт *ү* авиа бий” (Цолоо, [1982] 2011: 55) гээд дараах үгсээр жишээ авсныг IPA галигаар дүйцүүлэн хөрвүүлбэл: халх. [жmt^həŋ], хотгойд. [жmt^hāŋ], урианхай. [ɛmt^hiŋ] – *амьтан*; халх. [ke:t], хотгойд. [кж:t], урианхай. [kiʏe:t] – *гээд*; халх. [uxəŋ], хотгойд. [ухəŋ], урианхай. [ухiŋ] – *үхэр*; халх. [urəl], хотгойд. [үрəl], урианхай. [үгiŋ] – *үрэл* гэжээ. Мөн [ʃʃ], [ʃʃ^h]-ийн дараах эгшиг хойш хагас ижилссэн байдаг. Жишээ нь: халх. [ʃʃar], хотгойд. [ʃʃar], дөрвөд. [ʃʃiŋ] – *жар*; халх. [ʃʃatəl], хотгойд. [ʃʃ^hatəl], дөрвөд. [ʃʃ^hitəl] – *чадал* гэж халхынх шиг [i] эгшиг нь дэд үеийн эгшигтэй татагдан ижилссэн атлаа түүний арын [i] нь ойрадынх шиг сугаралгүй үлдсэнээр [ʃʃ], [ʃʃ^h] хэмээх өвөрмөц хувилбар бий болжээ.

Дархад аман аялгуунд [ш:] эгшгийг халхынхаас арай урдуур хэлдэг (Төмөртоого, [1967] 2002: 89) нь ойрадтай төстэй, харин [œ], [ʏ] эгшиг авиалбарын чанартай байдаг ([χʃləm] – *халим (тогооны таг)*, [tœyɾo:] – *тогоруу*, [tʰœyɾək] – *цогилог (тоононы голын дөрвөлжин зай)*, [ʏхгəχ] – *ухрах* гэх мэт) нь халхтай төстэй. Тус аялгуунд урт эгшгийн нэгэн сонирхолтой онцлог бий: [χo:səŋ] – *хоосон*, [tʰo:] – *тоо*, [ш:ʃ] – *өөш*, [œ:təs] – *өөдөс* гэх мэтээр *оуи, оуа* > [o:], *угь, уге* > [ш:] эгшиг хэлэх (Туяа нар, [2000] 2011: 186-200)-ээс гадна төв халх аялгууны ‘уу’ [o:] эгшгийг [ʰo:], ‘үү’ [u:] эгшгийг [ʰu:] гэдэг өвөрмөц хувилбараар хэлдэг. Жишээ нь: ДМХ. *ayula* > *a’ula* > *aoul* > ОЦМХ. дархад. [ʰo:l~o:l] – *уул*; ДМХ. *egyle* > *e’yle* > *eɣyl* > ОЦМХ. дархад. [ʰu:l~u:l] – *үүл* гэх мэт. “Дархад аялгууг судалсан олонх эрдэмтэн урт *ū* эгшгийг урт *ō* эгшгээр дууддаг гэдэгт санал нэг байдаг ч амьд аялгуунд урт *ū* ч биш, урт *ō* ч биш харин *“ū~^aō* эгшгүүдийн дундын байдалтай хэлэгдэж байгаа нь урт *ō* мэт сонсогддог. Энд эгшиг *ауи* нийлцээс урт эгшиг үүсэх явцын онцлогийг хадгалсан уг аялгууны өвөрмөц авиа гэж бид үзэж байна. Үлгэрлэвэл, *ауи* > *ай* > *аō* > *“aō* хэмээн хувьсжээ” (Дэлгэрмаа, [2015] 2023: 28-30). Яг иймэрхүү замаар монгол хэлний урт эгшиг үүссэн хөгжлийг эрдэмтэн Н.Н.Поппе “Introduction comparative studies to Mongolian” хэмээх бүтээлдээ тэмдэглэсэн байдаг (Поппе, 1956: 67-68). Дархад аман аялгуунд эр чанга урт [i:] эгшиг авиалбар байгаа ([акi:] – *агуй*, [jawəχtʰi:] – *явагтун* гэх мэт /Төмөртоого, [1967] 2002: 87-97/) нь монгол хэлний харьцангуй эрт үеийн шинжийг илэрхийлнэ. Мөн ойрад аялгуу шиг эгшгийн зохицолтой ([œ:lʰəχ] – *ойлгох*, [œ:rāltʰa:] – *ойролцоо*, [œ:mra:] – *уймраа*, [erхж:] – *эрхий*, [mɛlхж:] – *мэлхий*, [œтж:] – *өдий*, [tuлж:] – *дүлий* гэх мэт), зарим үгэнд өвөрхангайн

халх шиг [k/γ] гийгүүлэгчийн байранд [q/ɣ] хэлдэг ([tʰɔʷlɔq] – *цоглог*, [χotɔq] – *худаг* гэх мэт), зарим үгийг буриад аялгуутай төстэй хэлдэг (*čayalsun* > буриад. [sa:rʰaŋ], дархад. [tʰa:rɛs]) байдлаараа дээрх аялгуунуудын дундын шинжтэй. Ойрад, буриад болон дархад аман аялгуу бие заах нөхцөлтэй. Дархадад ганц тоонд [-w/-p], [-tʰ/-tʰ], олон тоонд [-wɪt] [-tʰ/-tʰ] хэлбэртэй байдаг. Жишээ нь: [pi awlɑ:w] – *би авлаа*, [ɔtʰsəmp] – *очсон би*, [pit awlɑ:wɪt] – *бид авлаа*, [awənɬʰ] – *чи авна*, [awənɬʰ] – *та / та нар авна*. Харьяалахын тийн ялгалын нөхцөл нь ойрад, буриад шиг [-a:/-e:], [-a:ŋ/-e:ŋ] хэлбэртэй. Үйл үгийн хоёрдугаар биед хүндэтгэн захирах нөхцөл нь буриадтай төстэй [-xtʰe:] хэлбэртэй. Хоёрдугаар биед шаардах нөхцөлийг [-a:tʰ/-ɔ:tʰ/-e:tʰ/-ə:tʰ], [-a:tʰ/-ɔ:tʰ/-e:tʰ/-ə:tʰ] гэж хэлдэг нь эгшгийн хувьд халх шиг, гийгүүлэгчийн хувьд ойрад шиг юм. Үгийн сангийн хувьд [jɔ:tɔ:] – *ёодоо* (яндан), [jantɔŋ] – *яндан* (зуух), [ʃana:] – *шанаа* (хатавч), [tʰɔtʰɛkpi: tʰawəŋ qɔlɔ:] – *тотгоны таван голоо* (хаалганы дээд талд тотгоны таван унь тогтоох тээглүүр), [χэхэ:r] – *хохоор* (хуурай мод), [saŋ] – *саж* (там томоор хагалсан түлээ) гэх мэт өвөрмөц үгс бий. Ийнхүү дархад аман аялгуу нь халх, ойрад, буриад аялгууны завсрын шинжийг илэрхийлэхээс гадна бас өөрийн гэсэн өвөрмөц онцлог бүхий аялгуу юм. Учир нь гарал, хүн амын бүтцийн хувьд үүсмэл буюу холимог угсаатны бүлэг юм. “Монголын Дархан, Дархад, Дархчуул овог нь улсын чанартай аливаа албан татвараас чөлөөлөгдсөн монголчууд юм. 1688 онд Засагт хан аймгийн ноён Гэлэг өөрийн харьяат нараас өндөр гэгээн Занабазарт шавь болгон өргөсөн хүмүүс” (Бадамхатан, 1964: 31) бөгөөд “XIX-XX зууны заагт одоогийн Булган аймгийн Могод, Төв аймгийн Өндөрширээт, Өвөрхангай аймгийн Бүрд, Хөвсгөл аймгийн Ринчинлхүмбэ, Улаан-Уул, Баянзүрх, (Хар дархад, Ухаа дархад), Дорнод аймгийн Чойбалсан, Халхгол (Хар дархад, Ухаа дархад, Жал дархад), Говь-Алтайн Чандмань, Эрдэнэ (Дархчуул), Ховд аймгийн Мянгад (Дархчуул), Дуут сумдад халх, мянгад, Алтайн урианхай ястны дунд байснаас үзэхэд нэлээд тархсан овог байжээ” (Бадамхатан, 1987:34).

1. Дүгнэлт

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэмтэн судлаачид 1950-1980-аад онд шинжилгээний ангиудаар явж, идэвхтэй судалж байсан тэр үеэс өнөөдөр даруй 40-70 жил өнгөрч, ард иргэд хөдөө орон нутгаас аймгийн төв, хот хүрээнд болон өөр өөр аймаг сумдын хооронд шилжин суурьших явдал тасралтгүй өрнөсөөр байна. Түүнээс гадна өдгөө бичиг үсэг мэдэхгүй, гэрийн ажилтай, орон нутгаасаа гарч хот суурин газар их, бага хугацаагаар явж үзээгүй, хэвлэл мэдээллийн сувагтай харьцдаггүй буюу нутгийн аялгуугаа цэврээр хадгалж буй хүмүүс бараг байхгүй болжээ. Иймд бидний судалж буй нутгийн аялгуутнууд бол гол төлөв хоёр аялгуутан юм. Өөрөөр хэлбэл тэд халхчуудтай ярих юм уу албан ажлын үед стандарт монгол хэлний суурь аялгуугаар ярьж, харин нутаг орондоо өөр хоорондоо өөрсдийн аялгуугаар ярьдаг хүмүүс юм. Тус хүрээлэнгээс 2022-2024 онд хэрэгжүүлсэн “Монгол хэлний нутгийн аялгууны судалгаа” сэдэвт суурь

судалгааны төслийн хамт олон монгол хэлний нутгийн аялгуутан, аман аялгуутан бүрийн, зарим салбар аман аялгуутны нутагт шинжилгээний ангиар явж, өнөөгийн байдлыг сурвалжлан судалсан юм. Үүнд: тухайн ястан угсаатан хүн ам тухайн сумд хэчнээн байгааг сумын хүний нөөцийн ажилтнаас тэмдэглэн авч, нас насны хүмүүстэй биечлэн уулзаж, аялгуугаараа ярьж байгаа эсэх, халх аялгуунд хэрхэн уусан жигдэрч байгаа, хэл аялгуунаас гадна ахуй соёл, ёс заншлаа хэр зэрэг уламжилж үлдсэнийг тодруулах зорилгоор аман асуулга статистик судалгаа хийх, аудио видео бичлэг хийх, тэмдэглэл хөтлөх зэргээр ажиллаж, тэр бүх материалдаа хэл шинжлэлийн үүднээс анализ шинжилгээ хийж, дата сан хөмрөг бүрдүүлсэн билээ. Энэхүү ажлын үр дүнд бид монгол хэлний нутгийн аялгуу, аман аялгуу, салбар аман аялгуунуудын хуваарилалтыг өнөөгийн бодит байдалд тулгуурлан шинэчлэн хийх, улмаар хэл – нутгийн аялгуу – аман аялгуу – салбар аман аялгуу болон завсрын аман аялгууны тодорхойлолтыг шинээр найруулан томъёолохыг оролдов.

Ном зүй

- АЯМ.,** (1998). *Атлас языков мира. (Консультанты издания: Бернард Комри, Стивен Мэттьюс, Мария Полински, Предисловие: Джина Эйтчисона, Перевод: Т.Парфеновой).* Москва. [Atlas yazykov mira [Atlas of the World's Languages]. Moscow. 1998.]
- Бадамхатан, С.** (1964). Дархад ястны хар дархад, элжигин, хоролнай овгуудын уг гарал, угсаа түүхийн асуудалд. *Халх, дархадын этнографийн бүтээл*, 50-60. [Badamkhatan, S. On the origin and history of the Darkhad, Eljigin, and Khorolnai of the Darkhad. *Khalkha darkhadiin etnografiin бүтээл*. Ulaanbaatar: 1964.]
- Бадамхатан, С.** ([1987] 2005). *Монгол улсын угсаатны зүй. III боть.* Улаанбаатар. [Badamkhatan, S. *Mongol ulsyn igsaatny züi III* [Mongolian ethnography]. Ulaanbaatar. 2005.]
- Батзаяа, Г.** (2008). *Монгол хэлний нутгийн аялгуунуудын авианы харьцуулал.* Улаанбаатар. [Batzaya, G. *Mongol khelnii nutgiin ayalguunuudyn avianу kharitsuulal* [Phonetic comparison of dialects of the Mongolian language]. Ulaanbaatar: 2008.]
- Батзаяа, Г., Батдорж, Ц., Баярчимэг, Э.** (2022). *Нутгийн аялгуу (“Монгол хэл судлал” 15 боть бүтээлийн VI боть).* Улаанбаатар: МУИС-ийн Монгол судлалын хүрээлэн. [Batzaya, G., Batdorj, Ts., Bayarchimeg, E. *Nutgiin ayalguu* [Dialect]. Ulaanbaatar: Institute for Mongolian Studies. 2022.]
- Батзаяа, Г. Самбуудорж, О., Боролзой, Д., Энхжаргал, С., Очирцэнд, М., Лхагважав, Б., Лхагвабаяр, Х., Отгончимэг, Б., Дэлгэрмаа, Г., Ариун-Онон, Г.** (2025). *Монгол хэлний нутгийн аялгууны судалгаа.* Улаанбаатар: Арвай принт. [Batzaya, G., Sambuudorj, O., Borolzoi, D., Enkhjargal, S.,

- Ochirsend, M., Lhagvajav, B., Lhagvabayar, H., Otgonchimeg, B., Delgermaa, G., Ariun-Onon, G. *Mongol khelnii nutgiin ayalguuny sudalгаа* [Study dialects of the Mongolian language]. Ulaanbaatar: ArvaiPrint. 2025.]
- Бат-Ирээдүй, Ж., Буянтогтох, Г., Өнөрбаян, Ц., Пүрэв-Очир, Б., Пүрэвжанцан, А.** (2014). *Монгол хэл шинжлэлийн тайлбар толь бичиг*. Улаанбаатар: МУИС пресс. [Bat-Ireedüi, J., Buyantogtokh, G., Önörbayan, Ts., Pürev-Ochir, B., Pürevjantsan, A. *Mongol khel shinjleliin tailbar toli bichig* [Mongolian Linguistic Dictionary]. Ulaanbaatar: MUISPress. 2014.]
- Владимирцов, Б.Я.** (1929). *Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия*. Ленинград. [Vladimircov, B.Ya. *Sravnitel'naya grammatika mongol'skogo pismennogo yazyka i khalkhaskogo narechiya* [Comparative grammar of the Mongolian written language and the Khalkha dialect]. Leningrad. 1929.]
- Гантогтох, Г.** (2010/2011). *Буриад аялгууны толь*. Улаанбаатар: Бэмби-сан пресс. [Gantogtoh, G. *Buriad ayalguuny toli* [Dictionary of Buriat dialect]. Ulaanbaatar: Bembi-san Press. 2010/2011.]
- Дөш, М.** (2025). Монгол Улс дахь буриадуудын хүн амын тоо. *Буриад судлал*. [Dösh, M. Buryat population in Mongolia. *Buriad sudlal*. XIII. 100-121. Ulaanbaatar: 2025.]
- Дэлгэрмаа, Г.** ([2015] 2023). *‘Мон-ө Ногөлд-Э’ дэх урт, хос эгшгийн судалгаа*. Улаанбаатар: Nepkod. [Delgermaa, G. *‘Mon-ö Nogöld-E’ dekh urt, khos egshgiin sudalгаа* [Study of Diphtong and Long vowel on the ‘Mon-ö Nogöld-E’]. Ulaanbaatar: Nepkod. 2023.]
- Заяабаатар, Д.** (2023). Орчин цагийн монгол хэлний бичгийн хэлний суурь аялгууны асуудалд. *‘Монголын энх тайван ба түүхэн туршлага’ сэдэвт олон улсын монголч эрдэмтний XII их хурлын илтгэлүүдийн эмхэтгэл*. [Zayabaatar, D. On the issue of the basic dialect of the modern Mongolian written language. *‘Mongolyn enkh taivan ba tiiukhen turshлага’ mongolch erdemtnii XII ikh khural*. Ulaanbaatar: 2023.]
- Зээнямбуу, Ч., Базаррагчаа, М.** (2014). *Хэл шинжлэлийн нэр томъёоны тайлбар толь*. Улаанбаатар: Адмон. [Zeenyambuu, Ch., Bazarragchaa, M. *Khel shinjleliin ner tomiyony tailbar toli* [Glossary of linguistic terms]. Ulaanbaatar: Admon. 2014.]
- Лувсанвандан, Ш.** ([1959] 2002). Монгол хэл, аялгууны учир, Улаанбаатар: 1959. *Монгол хэлний авиа зүйн онол практикийн асуудлууд* (2002). [Luvsanvandan, Sh. The reason for the Mongolian language and dialect. *Mongol khelnii avia züin onol praktikiin asuudluud*. Ulaanbaatar. 2002. 38-45.]
- Поппе, Н.Н.** (1956). Poppe, N.N. *Introduction comparative studies of Mongolian language*, Hylsinki. 1956.
- Пүрэвжав, Э., Ганболд, Д., Заяабаатар, Д., Энхжаргал, С., Эрдэнэтуяа, П., Баттогтох, Г.** (2022). *Бичгийн хэл (“Монгол хэл судлал” 15 боть бүтээлийн*

- XIII боть*). Улаанбаатар: МУИС-ийн Монгол судлалын хүрээлэн. [Pürevjav, E., Ganbold, D., Zayabaatar, D., Enkhjargal, S., Erdenetuya, P., Battogtokh, G. *Bichgiin khel* [Standart language]. Ulaanbaatar: Institute for Mongolian Studies. 2022.]
- Раднаев, Э.Р.** (1991). *Буряад хэлэнэй диалектологи*. Улаан-Үдэ: Бэлиг хэвлэл. [Radnayev, E.R. *Buryad khelenei dialektologi* [Dialectology of Buryat language]. Ulaan-Ud: Belig Press. 1991.]
- Ринчен, Б.** (1969). *Монгол ард улсын хамниган аялгуу*. Улаанбаатар: ШУА-ийн хэвлэл. [Rinchen, B. *Mongol ard ulsyn khamnigan ayalguu* [Khamnigan dialect of Mongolia]. Ulaanbaatar: Academy of Sciences Press. 1969.]
- Рамстедт, Г.И.** (1908). *Сравнительная фонетика монгольского письменного языка и халхаско-ургинского говора*. СанктПетербург. (Орчуулга, “Хэл зохиол” 1967, 4. I-IV). [Ramstedt, G.J. Comparative phonetics of the Mongolian written language and the Khalkha-Urga dialect (1908). *Khel zokhiol*. Ulaanbaatar. 1967, 4. I-IV]
- Санжаа, Ж., Надмид, Ж.** ([1993], [2008] 2018). *Монгол хэлний авиазүй ба авиалбарзүй*. Улаанбаатар. [Sanjaa, J., Nadmid, J. *Mongol khelnii avia züi ba avialbar züi* [Phonetic and Phonology of Mongolian language]. Ulaanbaatar. 2018.]
- Сэцэнбаатар.** (2005). *Sečenbayatur. Mongyol kelen-ü nutuy-un ayalun-u sinjilel-ün uduridgal*. Kökeqota: Ардын хэвлэлийн хороо. [Setsenbaatar. *Mongol khelnii nutgiin ayalguuny shinjilelin udirtgal* [Introduction to the Study of Mongolian dialects]. Hohhot: People’s Press Committee. 2005.]
- Төмөртоого, Д.** ([1967] 2002). Дархадын аман аялгууны урт эгшиг, тэдгээрийн үүслийн тухай товч тэмдэглэл, дархадын салбар аман аялгуу. *Монгол хэл шинжлэлийн онол, түүхийн асуудлууд*. [Tömörtogoo, D. A brief note on the long vowels of the Darkhad dialect and their origin. *Mongol khel shinjilelin onol, tүүkhiin asuudluud*. Ulaanbaatar. 2002. 87-97]
- Төмөртоого, Д.** (1992). *Монгол хэлний түүхэн хэлзүй*. Улаанбаатар. [Tömörtogoo, D. *Mongol khelnii түүkhen khel züi* [Historical Grammatik of Mongolian language]. Ulaanbaatar. 1992.]
- Төмөртоого, Д.** (2017). *Монгол хэлний түүхэн авиа зүйн үндэс*. Улаанбаатар: Соёмбо принтинг. [Tömörtogoo, D. *Mongol khelnii түүkhen avai züin үндэс* [Historical phonological foundations of the Mongolian language]. Ulaanbaatar: Soyombo printing. 2017.]
- Туяа, Д., Санжаа, Ж.** ([2000] 2011). Дархад аялгууны урт эгшгийг авиалбарын түвшинд судалсан нь. *Авиа – авиалбар – их авиалбарын тогтолцоо (Өгүүлэл, товхимлын эмхэтгэл)*. [Tuya, D., Sanjaa, J. The study of the long vowels of the Darkhad dialect at the phonetic level. *Avia – avialbar – их avialbar*. Ulaanbaatar. 2011. 186-200.]

- Убушаев, Н.Н.** (2006). *Дialeктная система калмыцкого языка*. Элиста: АОр‘НПП‘Джангар’. [Ubushayev, N.N. *Dialektnaya sistema kalmyckogo yazyka* [Dialect system of the Kalmyk language]. Elista: АОр‘NPP‘Jangar’. 2006.]
- Уртнасан, Д., Батдорж, Ц., Батхишиг, С.** (2022). *Авиа зүй (“Монгол хэл судлал” 15 боть бүтээлийн VIII)*. Улаанбаатар: МУИС-ийн Монгол судлалын хүрээлэн. [Urtnasan, D., Batdorj, Ts., Bathishig, S. *Avia züi* [Phonetic]. Ulaanbaatar: Institute for Mongolian Studies. 2022.]
- Хас-Эрдэнэ.** (2014). *Qaserdeni. Dayur kele ba mongyol kelen-ü qaričayulul (Qaserdeni-yin jokiyał büttügel-ün čiyulyan)*. Tüngliyoo qota: Jirim kompani. [Khas-Erdene. *Daguur khel ba mongol khelnii kharitsuulal* [Comparison Dagur and Mongolian languages]. Tüngliyoo: Jirim company. 2014.]
- Цолоо, Ж.** ([1982] 2011). *БНМАУ-ын нутгийн аялгуу (“Хэл зохиол судлал”, Боть XVIII. УБ., 1982). Орчин цагийн монгол хэлний нутгийн аялгуу*. [Tsoloo, J. *Orchin tsagiin mongol khelnii nutgiin ayalguu*. Улаанбаатар: Содпресс. [Dialects of Modern Mongolian Language]. Ulaanbaatar: Sodpress. 2011.]
- Цолоо, Ж.** (1988). *БНМАУ дахь монгол хэлний нутгийн аялгууны толь бичиг (II. Ойрад аялгуу)*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар. [Tsoloo, J., *BNMAU dakhi mongol khelnii nutgiin ayalguuny toli bichig (II. Oirat ayalguu)* [Dictionary of Dialects of the Mongolian language on the Mongolia (II. Oirat dialect)]. Ulaanbaatar: State Publishing. 1988.]
- Цэндээ, Ю.** (2012). *Ойрад аялгууны хэл зүй*. Улаанбаатар: Соёмбо принтинг. [Tsendee, Yu. *Oirat ayalguuny khel züi* [Grammatical of Oirat dialect]. Ulaanbaatar: Soyombo printing. 2012.]
- Шинэбаяр, О.** (2024). *Нийгмийн аялгуу судлал*. Улаанбаатар: Битпресс. [Shinebayar, O. *Niigmiin ayalguu sudlal* [Study Sociallect]. Ulaanbaatar: Bitpress. 2024].
- Янхунен, Ж.** (2003). Janhunen, J. (ed.), *The Mongolic Languages, Pouledge Language Family Series*. London, New-York. 2003.